СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ.

БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

№	Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	Төсөв /сая төгрөг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
ЗОРИЛГО-1. "МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГААР ДАМЖУУЛАН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭНД ЦАХИМ ТЕХНОЛОГИ НЭВТРҮҮЛЖ, ХҮНД-СУРТАЛ, АВЛИГА ҮҮСЭХ ЭРСДЭЛЭЭС ХАМГААЛНА."							
Зорилт 1. "Төрийн байгууллага, албан тушаалтныг авилгын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангаж, гүйцэтгэлийн үр дүнд тавих хяналтыг сайжруулна."							
1	1.1.Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг дүүргийн хэмжээнд хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангах.	10.0 ЗДТГ-ын төсөв	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар	-	100	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг дүүргийн хэмжээнд хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2024 оны 3 дугаар сарын 01-ний 3 зорилтын хүрээнд баталуулсан. Дүүргийн Засаг даргын 2024 оны А/132 дугаар захирамжаар төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлын хүрээнд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалтны ёс зүйн дүрмээс гадна Авлигатай тэмцэх газраас гаргасан авлигын эсрэг сурталчилгааны 34 төрлийн	100

						контент байршуулан тогтмол сурталчилж нийт 26,000 иргэдээс хандалт авсан байна. 2024 онд Авлигатай тэмцэх газар, Удирдлагын академи, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, дүүргийн Прокурорын газар, дүүргийн Цагдаагийн газар, "Элит сургалтын төв" зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран "Ёс зүйн зөрчилгүй хамт олон" аяныг зохион байгуулж давхардсан тоогоор 347 байгууллага аянд нэгдэж 23 удаагийн сургалт, 11 удаагийн өдөрлөг 1,752 албан хаагчдыг сургалтад хамруулсан. Сургалтаар 35 төрлийн 12,885 ширхэг тараах материал, гарын авлага, 1 шторк контент бүтээсэн. Мөн 500 гаруй иргэдээс байгууллагын үйл ажиллагаатай холбоотой судалгаа авсан. Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн албан хаагчид болон худалдан авах ажиллагааны үнэлгээний хороонд орж ажилладаг албан хаагчдад 2024 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр Авлигатай тэмцэх газартай хамтран зохион байгуулсан.	
2	1.2.Хүний нөөцийн ил тод байдлыг хангаж, сул орон тооны зарыг хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон дүүргийн www.shd.mn цахим хуудсанд тогтмол байршуулах.	1.6 ЗДТГ-ын төсөв	Байршуулсан мэдээллийн тоо	16	12	2024 оны жилийн эцсийн байдлаар Орон нутгийн өмчит аж ахуйт тооцоот үйлдвэрийн газрын захирлын сул орон тооны захиалгыг нийт 3 удаа журмын дагуу www.shd.mn цахим хуудсан байршуулан ажилласан. Мөн www.shd.mn цахим хуудсыг шинэчлэх ажил явагдаж байгаа тул	50

						Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын пэйж хуудсанд удирдах ажилтны сул орон тооны зарыг байршуулан ажилласан. Нийслэл дэх Төрийн албаны салбар зөвлөлд 2024 онд нийт 4 удаагийн сул орон тооны захиалгыг хүргүүлэн ажилласан.	
Зорилт 2. Төрийн үйлчилгээний шат дамжлагыг бууруулж, мэдээллийн техник технологийг сайжруулан "Цахим дүүрэг" хөтөлбөрийг хэрэгжүүлж, мэдээллийг цахимаар солилцох боломжийг бүрдүүлнэ.							
3	2.1."Цахим дүүрэг" хөтөлбөрийн 2024 оны төлөвлөгөөг батлуулан, хэрэгжилтийг хангах.	200,0 Дүүргийн төсөв	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар	70.0	90.0	Цахим дүүргийн хөтөлбөрийн хүрээнд иргэдэд төрийн үйлчилгээг хүртээмж хүргэхийн тулд СХД 43 хороонд хурдан цэг киокс машин шинээр байршуулахаар ажил хийгдэх төлөвлөгөөтэй байна. Хорооны өрхийн эмнэлэг цаг захиалгын киоск машинтай болсон иргэдэд хүндрэл төвөг учруулахгүй төрийн үйлчилгээ хурдан шуурхай авахад хялбар болсон. Сонгино хайрхан дүүрэг "Active Directory" буюу нэгдсэн систем холбогдож суурь хөгжүүлэлт хийгдэж үе шаттайгаар ажлыг төлөвлөгөөний дагуу явагдаж байна. СХД дүүргийн шилэн кабель болон бусад тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ тогтмол зохион байгуулан ажиллан, сүлжээний хэвийн байдлийг цаг тухай бүрт хурдан шуурхай найдвартай үйлчилгээ үзүүлэн ажилласан.	100
Зорилт 3. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, сургалтын дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, мэргэшсэн, чадварлаг ёс зүйтэй, хариуцлагатай төрийн албыг бүрдүүлнэ.							
4	3.1."Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр"-ийн 2024 оны төлөвлөгөөг батлуулан, хэрэгжилтийг хангах.	1,949.0 ЗДТГ-ын төсөв	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар	93.0	90-ээс дээш хувьтай хэрэгжсэн байх	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын "Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр"-ийг 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2024 оны 1 дүгээр	90

						сарын 22-ны өдөр 9 чиглэлийн хүрээнд 36 ажил, арга хэмжээг төлөвлөн батлуулсан. Хөтөлбөрийн хүрээнд нийт 36 ажил арга хэмжээг зохион байгуулж жилийн эцсийн байдлаар 90 хувьтай хэрэгжсэн байна.	

ХОЁРДУГААР ХЭСЭГ

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮНДСЭН ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД:

Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ

№	Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	Төсөв /сая төгрөг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар	Гүйцэтгэлийн хувь
ЗОРИЛГО 2. "МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, ЗАСГИЙН ГАЗРЫН БОДЛОГО ШИЙДВЭРИЙГ ХЭРЭГЖҮҮЛНЭ"							
Зорилт 4. Дүүргийн төрийн албан хаагчдыг авилгаас ангид, мэргэшсэн, ур чадвартай, тогтвортой ажиллах, нөхцөлийг бүрдүүлж, шатлан дэвшүүлэх, төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэж, төрийн албаны стандарт баримтлан мэдээллийн дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ.							
1	4.1.Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд хүлээн авч, хяналт тавих, баталгаажуулах, заавар зөвлөгөө өгөх, тайлан мэдээг үнэн зөв гаргаж, холбогдох байгууллагад мэдээлэх.	-	Мэдүүлэг гаргах албан тушаалтны тоо	283	60	"Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргасан албан хаагчдын "баталгааны маягт" хүлээн авах хуваарь"-ийг дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын батлуулж, 2024 оны 01-р сарын 18-ны өдрөөс 02-р сарын 15-ны өдрүүдэд хуваарийн дагуу хүлээн авч баталгаажуулсан.	90
		-	Заавар зөвлөгөө өгсөн албан тушаалтны тоо	283	60	2024 оны 1-р улирлын байдлаар ХАСХОМ мэдүүлсэн нийт 58 /шинэчлэн гаргасан 44, шинээр	90

						томилогдсон 8, ХАСУМ мэдүүлсэн 6/ мэдүүлэг гаргагч байна. Дээрх 58 мэдүүлэг гаргагчийн мэдүүлэгт хяналт тавьж, баталгаажуулах, заавар зөвөлгөө өгч ажилласан.	
		-	Үнэн бодитой мэдээлсэн тайлангийн тоо.	6	6	Дүүргийн хэмжээнд 2023 оны ХАСХОМ мэдүүлэх нийт 52 /Засаг даргын Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллага/ албан хаагчид хуулийн хугацаанд мэдүүлснийг хүлээн авч, тайлан мэдээг үнэн зөв гарган холбогдох байгууллагад хүргүүллээ.	100
2	4.2.Авлигын эсрэг хууль, тогтоомж, бодлого шийдвэрийг сурталчлах, мэдүүлэг гаргагч албан тушаалтанд зориулсан сургалт зохион байгуулах.	10,0 ЗДТГ-ын төсөв	Сургалтад хамрагдах хүн, тоо	645	350	Авлигатай тэмцэх газрын Сонгинохайрхан дүүргийн хариуцсан Н.Сүрэнжав комиссартай хамтран Дүүргийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдид болон Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дунд Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн танилцуулга сургалт, хэлэлцүүлгийг 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулсан. Сургалтад хэлэлцүүлэгт давхардсан тоогоор 365 албан хаагчид хамрагдсан.	100
3	4.3.Мэдээллийн технологи, программ хангамжийг хөгжүүлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах.	90.0 ЗДТГ-ын төсөв	Программ хангамжийг хөгжүүлэлт хийх ажлын гүйцэтгэлийн хувь	40	100	Active Directory буюу нэгдсэн систем үндсэн хөгжүүлэлтийг дуусаж дараагийн шатны хөгжүүлэлт ажил хийгдэх боломж нөхцөл бүрдсэн.	100

		10.0 ЗДТГ-ын төсөв	Мэдээллийн аюулгүй байдал хангагдсан байдал	31 хороо, нийт 290 албан хаагчид	43 хороо, нийт 300 албан хаагчид	Сонгинохайрхан дүүргийн 43 хорооны албан хаагчдыг нэгдсэн системд холбон програм хангамж, бүх төрлийн заавар зөвөлгөө зайнаас удирдан засвар үйлчилгээ үзүүлэх боломжтой болсон. 1. Насс төхөөрөмж дата файл хадгалах боломжтой болсон. 2. Виртал машин зайнаас удирдан үйлдлийн систем шинээр суулгах боломжтой болсон. 3. Зайнаас удирдан зохион байгуулан тусламж үзүүлэх боломжтой болсон.	
Зорилт 5. "Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, сургалтын дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, мэргэшсэн, чадварлаг ёс зүйтэй, хариуцлагатай төрийн албыг бүрдүүлнэ."							
4	5.1.Төрийн албан хаагчдын нийгмийн асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх.	200,0 ЗДТГ-ын төсөв	Нийгмийн асуудал шийдвэрлэсэн албан хаагчдын тоо	47	50	Дүүргийн Засаг даргын зөвлөлийн хурлын 2024 он 6 дугаар хуралдаанаар Засаг даргын Тамгын газрын Хөдөлмөрийн дотоод журмад заасны дагуу 68 албан хаагчдад 168,000,000 сая төгрөгний нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн. Мөн бусад өргөдөл, хүсэлтээр ирүүлсэн 77, нийт 145 албан хаагчид дэмжлэг үзүүлэн ажилласан.	100
5	5.2.Төрийн албан хаагчдыг богино болон дунд хугацааны, мэргэшүүлэх багц сургалтад үе шаттайгаар хамруулах.	50.0 ЗДТГ-ын төсөв	Сургалтад хамрагдах албан хаагч, тоо	48	40	Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад-5, мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад-3, Анх томилогдсон-3, богино хугацааны багц сургалтад-31, нийт 42 албан хаагч хамрагдсан.	100
6	5.3.Төрийн албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах.	18.0 ЗДТГ-ын төсөв	Сургалтад хамрагдах албан хаагч, тоо	1710	2000	Монгол бичгийн сургалтад -80, Удирдлагын академийн чадавхижуулах сургалтад -44,	100

						бусад сургалтад – 91, нийт 175 албан хаагч хамрагдсан байна. "Гүйцэтгэлийн төлөвлөгөө, Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал, ойлголт" сэдэвт сургалтад 25, "Архив, албан хэрэг хөтлөлтийн онол арга зүй", "eDoc" системийн ашиглалт (АБ04) сэдэвт цахим сургалтад 35, "Хяналт, Шинжилгээ үнэлгээ", "Үр дүнгийн тухай мэдээ бэлтгэх, тайлан боловсруулах ур чадвар" сэдэвт сургалтад 5, "Хөгжлийн бодлогын баримт бичгийн төлөвлөлт" сэдэвт сургалтанд 3, "Төрийн албан хаагчийн ёс зүй" сэдэвт цахим сургалтад 45, "Алсын хараа 2050" сургалтад 60 албан хаагч тус тус хамрагдсан байна.	
7	5.4.Төрийн дээд одон медаль, нийслэл, дүүргийн шагналаар шагнуулахаар аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс ирүүлсэн материалыг хүлээн авч хянан, холбогдох байгууллагад уламжлах, шагналын үйл ажиллагааг зохион байгуулах.	-	Шагналд тодорхойлогдсон иргэдийн тоо	1600	1300	Төрийн дээд одон медаль-1404 иргэнийг материалыг уламжилсан.	100
		-	Төрийн шагналаар шагнагдсан иргэдийн тоо	1139	1100	Алдарт эхийн одонгоор 1202, Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одонгоор 8, Цэргийн гавъяаны улаан тугийн одонгоор 2, "Алтан гадас" одонгоор 43, Хөдөлмөрийн хүндэт медалиар 16, нийт 1270 иргэн шагнагдагдсан.	
		-	Бусад шагналаар шагнагдсан иргэдийн тоо	366	500	Нийслэл Улаанбаатар хот үүсгэн байгуулагдсаны 385 жилийн ойн медалиар 1000, Салбарын шагналаар 171, Монголын Залуучуудын холбооны шагналаар 9, НИТХ-ын Хүндэт тэмдэг 21, НИТХ-ын Хүндэт өргөмжлөл 8, НИТХ-ын Хүндэт үнэмлэх 1, Нийслэлийн Тэргүүний	

						ажилтан 13, Нийслэлийн Засаг даргын Жуух бичиг-ээр 27, Дүүргийн ИТХ-ын Хүндэт тэмдэг 7, дүүргийн ИТХ-ын Хүндэт өргөмжлөл 11, дүүргийн Засаг даргын Хүндэт тэмдэг 689, дүүргийн Засаг даргын Хүндэт өргөмжлөл 838, нийт 2795 иргэн шагнагдсан.	
		50.0 ЗДТГ-ын төсөв	Дүүргийн Засаг даргын хүндэт тэмдэг, хүндэт өргөмжлөл захиалах	-	1000	2024 онд нийт 2000 ширхэгийг захиалсан.	
8	5.5.Засаг даргын Тамгын газар, хороодын албан хаагчдын шагналын судалгааг гаргаж, шагнаж урамшуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах.	-	Албан хаагчдын шагналын судалгаа гаргах	-	300	156 албан хаагчийн шагналын судалгааг гаргасан.	
		-	Шагнаж урамшуулсан албан хаагчдын тоо	-	50	Нийслэл Улаанбаатар хот үүсгэн байгуулагдсаны 385 жилийн ойн медалиар 1000, Салбарын шагналаар 171, Монголын Залуучуудын холбооны шагналаар 9, НИТХ-ын Хүндэт тэмдэг 21, НИТХ-ын Хүндэт өргөмжлөл 8, НИТХ-ын Хүндэт үнэмлэх 1, Нийслэлийн Тэргүүний ажилтан 13, Нийслэлийн Засаг даргын Жуух бичиг-ээр 27, Дүүргийн ИТХ-ын Хүндэт тэмдэг 7, дүүргийн ИТХ-ын Хүндэт өргөмжлөл 11, дүүргийн Засаг даргын Хүндэт тэмдэг 689, дүүргийн Засаг даргын Хүндэт өргөмжлөл 838, нийт 2795 иргэн шагнагдсан.	
9	5.5.Төрийн албан хаагчийн сахилга хариуцлагыг нэмэгдүүлж ёс зүйн зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах.	-	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	4	4	Засаг даргын Тамгын газрын дэргэдэх ёс зүйн зөвлөлтэй хамтран 4 удаагийн арга хэмжээ зохион байгуулан ажилласан. Үүнд:	100

						1. Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороо, "Ёс зүйн академи" төрийн бус байгууллагатай хамтран төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Засаг даргын Тамгын газрын албан хаагчдад ёс зүйн зөрчлөөс сэргийлэх арга зүйн мэдлэг эзэмшүүлэх сургалтыг 2024 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгуулсан. 2.Мөн дээрх сургалтыг хороодын албан хаагчдад 2024 оны 2024 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгуулж нийт 123 албан хаагч хамрагдсан. 3.Дүүргийн төрийн байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхжуулах сургалтыг Удирдлагын академийн Эрх зүйн тэнхимийн эрхлэгч, доктор, дэд профессор багш А.Алтанзул удирдан явуулж, Сургалтад Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа 13 байгууллага хамрагдсан. 4.Дээрх сургалтаар 28 сургууль, 64 цэцэрлэгийн Ёс зүйн дэд хорооны нийт 345 гишүүд хамрагдаж төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчлийг бууруулах талаар мэдээлэл солилцсон.	
10	5.6."Шинэ ажилтныг дадлагажуулах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх 2024 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангах.	40.0 ЗДТГ-ын төсөв	Хөтөлбөрт хамрагдсан албан хаагчдын тоо	36	20	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргаар 2022 оны 3 дугаар сарын 04-ний өдөр баталуулсан "Шинэ ажилтныг дадлагажуулах хөтөлбөр"-ийн 4 чиглэлийн	100

						хүрээнд төрийн захиргааны албан тушаалд 15, төрийн үйлчилгээний албан тушаалд 6, нийт 21 албан хаагч шинээр томилогдон хамрагдан ажилласан.	
11	5.7. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан баталгаажуулах, гүйцэтгэлийг тооцож ажиллах.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь, тоо	92	90	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 хэсэг, 16 зорилго, 34 зорилт, 213 арга хэмжээтэйгээр боловсруулан батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж эхний хагас жилийн гүйцэтгэл 59,9 хувьтай хэрэгжсэн. Жилийн эцсийн байдлаар 90,9 хувьтай хэрэгжсэн байна.	100
12	5.8.Дүүргийн Засаг даргын Тамгын газрын нэгж, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталгаажуулах, гүйцэтгэлийг тооцож ажиллах.	-	Төлөвлөгөө батлуулж, тайлагнасан нэгж	15	15	Засаг даргын Тамгын газрын 15 хэлтэс, тасгийн төлөвлөгөө батлагдсан. 15 хэлтсийн хагас жилийн тайланг нэгтгэж үнэлэх ажил хийгдсэн. Жилийн эцсийн тайланг 12 дугаар сарын 10-ны дотор үнэлж, дүгнэхээр тайланг нэгтгэн ажиллаж байна.	100
		-	Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллага	28	28	Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа 28 байгууллага төлөвлөгөөг батлуулсан. Жилийн эцсийн тайланг 12 дугаар сарын 10-ны дотор үнэлж, дүгнэхээр тайланг нэгтгэн ажиллаж байна.	
13	5.9.Дүүргийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагыг цаг үеийн мэдээ мэдээллээр шуурхай ханган, бодлого, арга зүйгээр хангаж ажиллах.	-	Зөвлөгөө, мэдээлэл, сургалтын тоо	4	4	Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудад: - Газар хөдлөлтийн гамшгийн үед зарлан мэдээллийн дохиогоор ажиллах тухай - Төрийн байгууллагын эзэмшилд байгаа автомашины улсын дугаарын суурь өнгийг цэнхэр өнгөөр солих ажлыг зохион	100

						байгуулж дүүргийн хэмжээнд бүртгэлтэй 186 тээврийн хэрэгслийн судалгааг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт хүргүүлсэн. - Богд ламын их дүйчэн буюу Зулын 25-нб өдрийг тохиолдуулан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Гандантэгчинлэн хийдийн Тэргүүн хамба ламын ажлын албатай хамтран 1008 зул өргөх арга хэмжээ - Нийслэлийн 385 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд тухайн байгууллагад олон жил бүр бүтээлтэй ажилласан албан хаагчдад Нийслэлийн 385 жилийн ойн медаль болон бусад шагналаар шагнуулах зэрэг цаг үеийн мэдээ, мэдээллээр тухай бүр ханган ажилласан.	
14	5.10.Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч, судлан шийдвэрлэх.	-	Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын тоо	7542	7500	Дүүргийн хэмжээнд нийт 5276 өргөдөл, гомдол ирснээс шийдвэрлэсэн 5103, судалж байгаа 173, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 9 өргөдөл, гомдол байна. Үүнээс 2127 буюу 40,31% нь хүсэлт, 2593 буюу 49,15% гомдол, 471 буюу 8,93% талархал, 77 буюу 1,46% санал, 8 буюу 0,15% нь мэдэгдэл ирсэн байна. Өргөдөл, гомдлын тоо өмнөх оны энэ үед 7208 буюу 27 хувиар буурсан байна.	100
		-	Шийдвэрлэлтийн дундаж хугацаа	7 хоног, 4 цаг 52 минут	7 хоног	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 7 хоног 20 цаг 46 минут буюу өмнөх оны шийдвэрлэлтийн	

						дундаж хугацаатай нэг үзүүлэлтэй байна.	
		-	Зөрчлийн тоог бууруулах	301	260	Дүүргийн хэмжээнд өргөдөл, гомдлыг шийдвэрлэх явцад нийт 267 зөрчил гарснаас өдөрт нь багтаан хүлээн аваагүй 118, өдөрт нь багтаан шилжүүлээгүй 63, явцын тэмдэглэл хөтлөөгүй 81, дахин хандах үндэслэлтэй 2, буцаалтыг 3 хоногт багтаан хийгээгүй 3 зөрчил гарсан байна. Зөрчил гаргасан харьяа байгууллага, хэлтэс тасагт зөвлөмж, чиглэлийг албан бичгээр хүргүүлж, албан хаагчдад зөвлөгөө мэдээллийг тогтмол өгсөн.	
15	5.11. Дүүргийн 16, 39, 40, 42, 43 дугаар хороодын цогцолбор байрыг ашиглалтад оруулах ажлын эрчимжүүлж, хяналт тавих.	2,300.6 Улсын төсөв, 4,218.9 Нийслэлийн төсөв	Ашиглалтад орох барилга, тоо	0	5	Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар дүүргийн 16, 39, 40, 41, 42, 43 дугаар хорооны цогцолбор байруудын барилгын ажил он дамжин хийгдэж байна. 39 дүгээр хорооны цогцолбор байр 90%, 40 дүгээр хорооны цогцолбор байр 95%, 41 дүгээр хорооны цогцолбор байр 90%, 42 дугаар хорооны цогцолбор байр 95%, 43 дугаар хорооны цогцолбор байрын ажлын явц 90%-ийн гүйцэтгэлтэй байна. 2024 оны 3-р улиралд 16-р хорооны цогцолбор байр бүрэн ашиглалтад орж, хороо, өрхийн эмнэлэг, Улсын бүртгэлийн Өнөр цэг, камерын хяналтын дэд төв зэрэг төрийн байгууллагууд үйл ажиллагаа хэвийн явуулж, иргэд олон нийтэд төрийн үйлчилгээг хүргэж байна.	60

16	5.12.Хороодыг цаг үеийн мэдээ мэдээллээр шуурхай ханган, албан хаагчдын ажлын цаг ашиглалтад хяналт тавьж, удирдлага, арга зүйгээр хангах.	-	Үүрэг даалгаврын тоо, хэрэгжилтийн хувь	461 удаа үүрэг, даалгавар өгч, хэрэгжилт 100 хувь	90-ээс дээш хувьтай хэрэгжсэн байх	2024 оны жилийн эцсийн байдлаар хороодод нийт 200 удаагийн үүрэг даалгавар хүргүүлснээс хэрэгжилт 81,5%-тай байна.	85
		2.0 ЗДТГ-ын төсөв	Хороодын албан хаагчдын ажлын цаг ашиглалтад тавих хяналтын тоо	23	12	Хороодын албан хаагчдын ажлын цаг ашиглалтад сар бүр хяналт тавьж, нийт 12 удаагийн цагийн тооцоог гаргаж, Санхүүгийн тасагт хүргүүлсэн байна.	
		6.0 ЗДТГ-ын төсөв	Арга хэмжээний тоо	-	4	1. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны А/119 дүгээр тушаалаар хороодын албан хаагчдын дунд харилцан суралцах арга зүйн сургалтыг зохион байгуулсан. 2. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны "Сонгинохайрхан дүүргийн хороодын үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт, шалгалт хийх, зөвлөн туслах ажлын удирдамж"-ийн дагуу 3-р улиралд 43 хороодод хяналтаар явж, зөвлөн туслах ажлыг Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэстэй хамтран зохион байгуулсан. 3. 2024.11.12-ны өдөр дүүргийн Засаг даргын 2024 оны А/642 дугаар захирамжаар 43 хорооны 398 хэсгийн ахлагч нарын дунд мэдлэг боловсролыг дээшлүүлэх, төр, захиргааны байгууллагын холбогдох шийдвэрийн талаар мэдлэг олгох, тэдний санал, хүсэлтийг сонсох, ажлын үр дүнгийн талаар хэлэлцэх, шийдвэрлэх сургалт, уулзалтыг	

						Хүүхэд залуучуудын театрт зохион байгуулан ажилласан.	
17	5.13.Дүүргийн Засаг даргын Тамгын газарт хэрэгжүүлж буй ISO 9001:2015 стандартын хэрэгжилтийг хангана.	15.0 ЗДТГ-ын төсөв	Магадлан аудитаар орох	Олон улсын баталгаажуулалтын 2 дахь удаагийн гэрчилгээ авсан.	Олон улсын баталгаажуулалтын 3 дахь удаагийн гэрчилгээ авсан байх.	2024 оны Чанарын менежментийн тогтолцооны төлөвлөгөөг боловсруулан, ажлын хэсэг холбогдох баримт бичгийг бүрдүүлэн Global Quality LLC-тэй гурав дахь шатны баталгаажуулалтын гэрчилгээг авсан.	100
Зорилт 6.“Гадаад, дотоод хамтын ажиллагаатай аймаг, сум, дүүрэг, хотуудтай хамтарч ажиллана.”							
18	6.1.БНСУ-ын Сёнбук, Канбук дүүрэг, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр, Рашаан хоттой байгуулсан хамтын ажиллагааг бэхжүүлэх.	200.0 ЗДТГ-ын төсөв	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	5	5	- Рашаан хотын удирдлагуудтай цахимаар хуралдаж 10 жилийн ойг тэмдэглэх, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх талаар цахим хурал хийж Ажлын хэсэг байгуулсан. -2024 оны 05 дугаар сарын 08-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын урилгаар Хайлаар дүүргийн Засаг даргын Тамгын газрын удирдлагууд айлчлал хийсэн. -Япон Улсын Шизуока мужийн Изүнокүни хот болон Сонгинохайрхан дүүрэг нь 5 дахь жилдээ хамтран ажиллаж байгаа ба иргэдийн бүлгийн 12 зочин, 19 хүүхэд, 2 багшийг хүлээн авч, хөтөлбөрийн дагуу холбогдох арга хэмжээг зохион байгуулан ажилласан. -2024 оны 11 дүгээр сарын 09-ний өдрөөс 13-ны өдрүүдэд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хайлаар дүүргийн дарга бусад албаныхан айлчилж, Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга 2025 онд хамтран ажиллах төлөвлөгөөнд гарын үсэг зурсан	100

19	6.2.Хэнтий аймаг болон бусад аймгийн ЗДТГ-тай хамтын ажиллагааны гэрээ байгуулахаар судалж, туршлага солилцох.	20.0 ЗДТГ-ын төсөв	Харилцан туршлага судлах арга хэмжээний тоо	2	2	2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 01/695 дугаар албан бичгээр Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газарт хамтран ажиллах хүсэлт хүргүүлсэн боловч хариу ирээгүй болно.	30

ГУРАВДУГААР ХЭСЭГ

Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ

№	Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	Төсөв /сая төгрөг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар	Гүйцэтгэлийн хувь
ЗОРИЛГО 3. ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ БОЛОН БУСАД ХУУЛЬ ТОГТООМЖ, ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ХАРЬЯАЛАХ ДЭЭД ШАТНЫ ЗАСАГ ДАРГЫН ШИЙДВЭРИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ХАНГАХ АЖЛЫН ХҮРЭЭНД:							
Зорилт 7. Байгууллага, нэгжийн үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг үзүүлж, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх. а							
1	7.1.Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлангийн үнэлж, дүгнэн урамшуулал олгох.	-	Төлөвлөгөө батлуулсан албан хаагчдын тоо	300	290	ЗДТГ-78 албан хаагч, Зохион байгуулагч – 44, нийгмийн ажилтан-35 албан хаагч гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулсан.	90
		-	Гүйцэтгэлийн тайланг дүгнүүлсэн албан хаагчдын тоо	299	290	Эхний хагас жилийн байдлаар Засаг даргын Тамгын газрын төрийн захиргааны 76, үйлчилгээний 40, хорооны зохион байгуулагч 55, нийгмийн ажилтан 30, үйлчилгээний нийт 247 албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг дүгнэсэн. Жилийн эцсийн ажлыг дүгнэхээр ажиллаж байна.	
		280.0	Мөнгөн урамшуулалд	272.3 сая	280.0 сая	244,546,022 сая төгрөгийн урамшууллыг олгосон байна.	

		ЗДТГ-ын төсөв	зарцуулсан мөнгөн дүн				
2	7.2.Дээд газраас ирүүлсэн тогтоол, шийдвэрийн биелэлтийг тооцож, хэрэгжилтийг хангах.	-	Хяналтад авсан тогтоол, шийдвэрийн тоо,	13	10	Дээд газраас ирсэн 9 тогтоол шийдвэрийн биелэлтийг ханган ажиллаж, Хууль, эрх зүйн хэлтэст биелэлтийг хүргүүлсэн.	90
		-	Хэрэгжилтийн хувь	100	100		
3	7.3.Дүүргийн Засаг даргын захирамж, Тамгын газрын даргын тушаалыг хууль зүйн болон утга найруулгын алдаагүй боловсруулах, хэрэгжилтийг хангах, тайлагнах.	-	Боловсруулсан захирамж, тушаалын тоо	Захирамж 100, тушаал 439 гаргасан	Захирамж 100, тушаал 400.	Засаг даргын Б захирамж-69, А захирамж-55, Засаг даргын Тамгын газрын даргын тушаал 246 боловсруулсан байна.	80
		-	Хэрэгжилт, хувиар	100	100	Хүний нөөцийн чиглэлээр нийт 183 шийдвэрийг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	
4	7.4.Хэлтэст ирсэн, явуулсан бичиг, өргөдөл гомдлын бүртгэл шийдвэрлэлтэд хяналт тавин, баримт бичгийн эргэлтийн мэдээг сар тутамд гаргаж танилцуулах.	-	Ирсэн бичгийн шийдвэрлэлт, хувиар	100	100	Төрийн захиргааны удирдлагын хэлтэст 896 бичиг ирсэн. Үүнээс хариутай 60, хариугүй 836, Хугацаандаа хаасан 885 бичиг байна. Ирсэн бичгийн шийдвэрлэлтийн хувь 100.	100
		-	Явуулсан бичгийн тоо	340	300	277 бичиг илгээснээс хариутай 47, хариугүй 230 байна. Шийдвэрлэлтийн хувь 100.	
		-	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн зөрчлийг бууруулсан хувиар	86.0	50.0	Төрийн захиргааны удирдлагын хэлтэст нийт 148 өргөдөл, гомдол ирснээс шийдвэрлэсэн 148, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 2 өргөдөл, гомдол байна. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 10 хоног 8 цаг 14 минут буюу өмнө оны үетэй харьцуулахад 2 хоногоор буурсан, нийт гарсан зөрчил 6, өмнөх оны энэ үед нийт 17 зөрчил буюу 64,7 хувиар буурсан байна.	
5	Архивын байнга болон түр хадгалах нэгжийг үүсгэж, шилжүүлэх ажлыг зохион байгуулах	-	Үйл ажиллагааны	100	100	Байнга-25, Түр-127 баримт хүлээлгэн өгсөн.	100

			хэрэгжилт, хувиар				

ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

№	Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар	Гүйцэтгэлийн хувь
ИРГЭДЭД ЧИГЛЭСЭН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ							
1	1.Дүүргийн удирдах албан тушаалтнуудын иргэдтэй хийх уулзалтыг зохион байгуулах.	-	Уулзалтын тоо	13	12	Дүүргийн удирдах албан тушаалтнуудын иргэдтэй хийх уулзалт 9 удаагийн 78 иргэний санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн байна. Уулзалтаар хандсан хүсэлтийг ангилан авч үзвэл: Нийгмийн асуудал шийдвэрлүүлэх- 18 Газар эзэмших, өмчлөх, маргаантай асуудлаар- 8 СӨХ-ны үйл ажиллагааны тухай-7, Шагналын асуудлаар-6, Бусад асуудлаар 39 үүнээс иргэний талд шийдвэрлэсэн 52, боломжгүй хариу өгсөн 26 санал, хүсэлт байна.	80
БАЙГУУЛЛАГА, АЖ АХУЙН НЭГЖИД ЧИГЛЭСЭН ҮЙЛЧИЛГЭЭ							
2	1. Дүүргийн 1, 8 дугаар хороонд ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.	10.0 ЗДТГ-ын төсөв	2 дахь удаагийн гэрчилгээ авах	Олон улсын баталгаа жуулалтын 1 дэх удаагийн	Олон улсын баталгааж уулалтын 2 дахь удаагийн гэрчилгээ	Улсын Их Хурлын сонгуулийн дараагаар "Менежмент ба ур чадварын хүрээлэн" аудитын шалгалт зохион байгуулж 1 хороо шалгалтад тэнцэж, гэрчилгээ авахаар болж, 8	50

				гэрчилгэ э авсан.	авсан байх.	дугаар хороо дахин аудитын шалгалтад орохоор болсон.	
Нийт							**94,8.**

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
8 дугаар хавсралт

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН Ж.ДУЛАМСҮРЭНГИЙН 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА Ж.ДУЛАМСҮРЭНГИЙН 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр:Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар
Нэгжийн нэр: Төрийн захиргааны удирдлагын хэлтэс

Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин	Нийт (70 оноо)
1	2	3	4
1.	Гэрээний биелэлт	94,3	66.1

4. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Удирдлагын академийн мэргэшүүлэх багц сургалт	Удирдлагын академийн мэргэшүүлэх ахлах түшмэлийн сургалтад хамрагдсан.	15.0
2.	Монгол бичгийн сургалт	Монгол хэлний тухай хуульд төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагууд 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс албан хэргээ крилл, үндэсний хос бичгээр хослуулан явуулна гэж заасны дагуу Монгол бичгийн сургалтад хамрагдсан.	12.6
3.	Бусад	Ёс зүйн болон бусад сургалтуудад тухай бүр хамрагдсан.	12.0
Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо			13.0

5. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ

Д/д	Үзүүлэлт	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Хандлага, ёс зүй	10.0
2.	Удирдан зохион байгуулах	10.0
3.	Асуудал шийдвэрлэх	12.0
4.	Манлайлах	12.0
5.	Багаар ажиллах	10.0
6.	Харилцаа	12.0
Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо		11.0

6. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт)*	66.1
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт *(Төсвийн шууд захирагчийн үнэлгээ)*	13.0
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Төсвийн шууд захирагчийн үнэлгээ)*	11.0
4.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)*	–
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо		90,1

Үнэлгээ өгсөн:

Тамгын газрын дарга
(албан тушаал)

Төсвийн шууд захирагч

Д.....
. (гарын үсэг)

(Д.Төмөрбаатар)
албан хаагчийн нэр)

2024.12.17.
(огноо)

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:

Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
(албан тушаал)

Нэгжийн дарга:

.....
. (гарын үсэг)

(Ж.Дуламсүрэн)
(албан хаагчийн нэр)

2024.12.18
(огноо)

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН ХЭЛТСИЙН
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ.

БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

№	Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	Төсөв /сая төгрөг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
Зорилт 1.1. Ногоон хөгжлийн бодлого:							
1	1.1.1.Нийслэлийн ногоон байгууламжийг сайжруулах оновчтой менежментийг хэрэгжүүлэн, цэцэрлэгт хүрээлэн байгуулж, нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх.	800,0 дүүргийн төсөв	Ногоон байгууламжийн хэмжээ, хувь	4.8	5.2	Дүүргийн 17, 29 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Хот тохижуулахын 39,0 сая төгрөгийн санхүүжилтээр нийтийн эзэмшлийн 1306 м.кв талбайд шинээр зүлэгжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Ногоон байгууламжийн 73008 м.кв талбайн арчилгааг хувийн хэвшлийн 5 аж ахуйн нэгж байгууллага хариуцан 8655 тарьц суулгацыг тарьж, нийтийн эзэмшлийн талбайн цэцгийн мандалд 15350 ширхэг цэцэг тарьж, 11850 м.кв талбайг шинээр зүлэгжүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн. Баянхошууны Бумбат толгойн 11,000 м.кв талбайд шинээр төгөл байгуулах ажлыг зохион байгуулж, 31 төрийн байгууллага, 43 хорооны 537	100

						албан хаагчид 27 нэр төрлийн 2245 ширхэг тарьц суулгацыг тарих ажлыг хийж гүйцэтгэсэн. Дүүргийн 2, 5, 7, 13, 14, 16, 17, 19, 24, 25, 33, 41 дүгээр хороодын 20 байршлын 57469 м.кв талбайд 20 бичил цэцэрлэгт хүрээлэнг шинээр байгуулсан. Дүүргийн хэмжээнд 2020 онд нэг хүнд ногдох ногоон байгууламж 3,5 м.кв, 2024 оны байдлаар 5,2 м.кв болж өссөн үзүүлэлттэй.	
2	1.1.2.Хотын тоосжилтыг бууруулж, иргэдэд ээлтэй орчныг бүрдүүлэх./1, 2, 3, 4, 5, 6, 8, 9, 10 дугаар хороо/	6,460,4 дүүргийн төсөв	Ашиглалтад орсон талбай, м2	16160м2	18160м2	Хотын тоосжилтыг бууруулж, иргэдэд ээлтэй орчныг бүрдүүлэх зорилгоор дүүргийн болон орон нутгийн хөгжлийн сангийн 3,4 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 5, 6, 8, 17, 23, 28, 29, 30, 35, 43 дугаар хороодын 11,799 мкв талбайд явган хүний зам, шатыг, 9, 11, 12, 13, 15, 16, 19, 20, 27, 20, 31 дүгээр хороодын 16 байршлын 16,448 мкв талбайд авто зогсоолыг шинээр байгуулж ашиглалтад оруулсан. Нийслэлийн төсвийн 80.0 сая төгрөгийн санхүүжилтээр 1 дүгээр хорооны Толгойтын 114, 115 дугаар гудамжны дунд 3200 м.кв талбайд чийрэгжүүлэлтийн талбайг шинээр байгуулсан.	100
ЗОРИЛГО 2. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО:							

Зорилт 2.1. Төр хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлж, олон улсын болон гадаад дотоодын байгууллагуудтай хамтран ажиллаж хөрөнгө оруулалтыг татаж, жижиг дунд үйлдвэрлэл, бизнесийг хөгжүүлэх таатай орчныг бүрдүүлж, тэдгээрийн оролцоог нэмэгдүүлнэ.							
3	2.1.1.Улаанбаатар хотын тогтвортой зам тээврийн хөгжил төсөл хэрэгжүүлэхэд хамтарч ажиллах.	ОУБ-ын хөрөнгө	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	0	40	Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банкны санхүүжилтээр "Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төсөл"-ийн хүрээнд "Өнөр хорооллын гудамж (2,8 км), Үйлдвэрчний эвлэлийн гудамж (5,6 км) замыг шинэчлэн засварлах ажлын зураг төсөв батлагдсаны дагуу зам барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, "Макс рөүд" ХХК, "Арж капитал" ХХК-иуд шалгарч 2025 оны 04 дүгээр сарын 01-ны өдрөөс авто замын ажлууд хийгдэнэ.	40
ЗОРИЛГО 3. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО:							
Зорилт 3.1. Гэр хорооллын иргэдийн усны хангамжийг сайжруулж, ухаалаг худаг төслийг хэрэгжүүлж, иргэдийг 24 цагийн турш ундны усаар хангана.							
4	3.1.1.Гэр хорооллын айл өрхүүдийг цахилгаан эрчим хүчээр хангах ажлыг үргэлжлүүлэх /1, 3, 21, 22, 28, 31, 32, 33, 36, 40, 42 дугаар хороод/	40,0 НОНХС 234,252, 3 ДОНХС	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	70%	100%	Улсын төсвийн 6,1 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 1, 3, 21, 22, 26, 31, 32, 33, 36 нийт 9 хорооны цахилгаангүй, хүчдэлийн уналттай 1770 айл өрхүүдийг цахилгааны эрчим хүчинд холбох ажлыг "Энержи тех" ХХК, "Хайрхан наран трейд" ХХК, "Эрчим энержи"ХХК-иуд хийж гүйцэтгэн бүрэн ашиглалтад оруулсан. Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 134,2 сая төгрөгийн санхүүжилтээр 21	100

						дүгээр хорооны цахилгаангүй болон хүчдэлийн уналттай 31 айл өрхийг бүрэн холбож ашиглалтад оруулсан. Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 310,0 сая төгрөгийн санхүүжилтээр 31, 36 дугаар хороодын цахилгаангүй болон хүчдэлийн уналттай 63 айл өрхийг цахилгаанд холбох ажлын сонгон шалгаруулалтыг зарлаж "Ингүүмэл эрчим" ХХК, "Кон арч" ХХК–ууд шалгарч гэрээ байгуулсан.	
5	3.1.2.Хүн амын тоонд нийцүүлэн гүний худаг, зөөврийн ус түгээх байр барьж ашиглалтад оруулах /23, 24, 32, 33 дугаар хороо/	240,0 НОНХС 546,2 ДОНХС	Ашиглалтад оруулах худаг, тоо /7 зөөврийн ус түгээх байр/	40%	100%	Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд зөөврийн ус түгээх байр 150, ухаалаг төхөөрөмжтэй 32, төвлөрсөн системд холбогдсон 54 нийт 236 ус түгээх байр үйлчилгээ явуулдаг. Төвлөрсөн системд холбогдсон 54 ус түгээх байранд Мянганы сорилтын сангийн буцалтгүй тусламжаар ухаалаг төхөөрөмж суурилуулсан. Дүүргийн төсвийн 276,6 сая төгрөгийн санхүүжилтээр 23 дугаар хорооны Хангай 1 дүгээр гудамж, 33 дугаар хорооны Бөөр булгийн гудамжид шинээр баригдах зөөврийн ус түгээх байр барих сонгон шалгаруулалтыг зарласан. Дүүргийн төсвийн 276,0 сая төгрөгийн санхүүжилтээр 24	100

						дүгээр хорооны Салхитын 6 дугаар гудамж, 32 дугаар хорооны Эмээлтийн 1 дүгээр гудамжинд зөөврийн ус түгээх байр барих ажлыг "Урал их" ХХК гүйцэтгэж, байнгын ашиглалтад оруулсан. Нэгдсэн үндэстний байгууллагын Хүүхдийн сангийн 136,8 сая төгрөгийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төслөөр 24 дүгээр хорооны Баянхайрханы гудамжинд байрлах 947 дугаар зөөврийн ус түгээх байр барих ажлыг "Урал их" ХХК гүйцэтгэн ашиглалтад оруулсан.	
6	3.1.3. 154 дүгээр сургуулийн арын туслах замыг Үйлдвэрчний эвлэлийн гудамжтай холбох	100,0 ДОНХС	Ашиглалтад оруулах авто зам, км	0%	70	Дүүргийн төсвийн 50,0 сая төгрөгийн санхүүжилтээр Үйлдвэрчний эвлэлийн төв замаас 37 дугаар хорооны Хангайн гудамжны 0,7 км авто замын зургийн ажлыг "Жи Ар Си" ХХК хийж гүйцэтгэсэн.	70
ЗОРИЛГО 4. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО:							
Зорилт 4.1. Ойн зурвас, ногоон төгөл, цэцэрлэгт хүрээлэн барьж байгуулан нэг хүнд ноогдох ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.							
7	4й.1.1."Тэрбум" мод үндэсний хөдөлгөөний арга хэмжээг зохион байгуулж, Гэр хорооллын айл өрхүүдийг хашаандаа мод тарихыг уриалж, дэмжлэг үзүүлэх.	500,0 Дүүргийн төсөв	Тарих мод, тоо	189576	200000	Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, "Ногоон хот-Иргэдийн оролцоо" аяны хүрээнд дүүргийн Засаг даргын А/268, А/571 дүгээр захирамжаар 43 хорооны 12057 иргэд, 678 аж ахуйн нэгж байгууллагын 3208 ажилтан албан хаагчид оролцож 152,630 ширхэг мод бут сөөгийг тарих ажлыг хийж гүйцэтгэсэн. Дүүргийн төсвийн хот	100

						тохижуулах зардлын 171,5 сая төгрөгийн санхүүжилтээр 43 хороодын 4934 айл өрх, 85 аж ахуйн нэгж байгууллагад 47280 тарьц суулгацыг тарааж тарих ажлыг зохион байгуулсан.	
8	5.1.2.Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага бүр орчны 50 м газартаа мод, бут, сөөг тарьж, зүлэгжүүлэлт хийх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллах.	-	Тарих мод, тоо	9500	10000	Засаг даргын дэргэдэх 68 төрийн байгууллагын 537 ажилтан албан хаагч 2245 ширхэг тарьц суулгац, хувийн хэвшлийн 1137 аж ахуйн нэгж, байгууллагуудын орчны 50 метр талбайд 20,466 ширхэг мод бутыг, нийт 1205 төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд 22,711 ширхэг тарьц суулгацыг тарих ажлыг зохион байгуулсан. Дүүргийн хэмжээнд төрийн болон хувийн хэвшлийн 35 сургууль, сургуулийн өмнөх боловсролын 115 цэцэрлэгүүд хавар намрын бүх нийтээр мод тарих өдрөөр 16607 тарьц суулгацыг тарьж, ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн.	100
9	5.1.3.Хороодын нийтийн эзэмшлийн талбайн тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх.	200,0 Дүүргийн төсөв	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	25%	100%	Иргэдийн ая тухтай амьдрах орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор Дүүргийн төсөв, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 5, 6, 8, 17, 23, 28, 29, 30, 35, 43 дугаар хороодын 11799,8м2 талбайд 1,159,218,700 төгрөгөөр явган хүний зам, шат, 9, 11, 12, 13, 15, 16, 19, 20, 27, 20, 31 дүгээр	100

						хороодын 16 байршлын 16448м2 талбайд 2,309,990,503 төгрөгөөр авто зогсоол, 2, 10, 14, 27, 28, 37, 42 дугаар хороодын 7 байршилд 671,552,200 төгрөгөөр хүүхдийн тоглоомын талбай, 18, 28, 31, 38 дугаар хороодын 4 байршилд 455,578,910 төгрөгөөр 3х3 сагсан бөмбөгийн талбай, 28, 23 дугаар хорооны 2 байршилд 781,474.80 төгрөгөөр гадна талбайн тохижилтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Дүүргийн 33 дугаар хорооны нутаг дэвсгэрийн "Цагдаа толгой" цэцэрлэгт хүрээлэнд Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасаг, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд, хороодын Засаг даргын ажлын албаны 395 төрийн ажилтан, албан хаагчид оролцож, 1000 ширхэг хайлаас, 1200 ширхэг шар хуайс, нийт 2200 ширхэг тарьц суулгацыг тарих ажлыг хийж гүйцэтгэсэн.	
10	5.1.4.Баянхошуу хайрханы бэлд 2 га газарт цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлыг үргэлжлүүлж, Хамбын овооны цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлыг эхлүүлэх.	1,700.0 АХБ, 3,000.0 Нийслэлийн төсөв	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	80%	100%	Баянхошууны Бумбат толгойн 11,000 м.кв талбайд шинээр төгөл байгуулах ажлыг зохион байгуулж, 31 төрийн байгууллага, 43 хорооны 537 албан хаагчид 27 нэр төрлийн 2245 ширхэг тарьц суулгацыг тарих ажлыг хийж гүйцэтгэсэн. Дүүргийн төсвийн 462,0 сая	70

						төгрөгийн санхүүжилтээр 39 дүгээр хорооны нутаг дэвсгэр Хамбын овооны цэцэрлэгт хүрээлэнгийн хамгаалалтын хашаа барих ажлын сонгон шалгаруулалт зарлагдаж, "Би кэй би констракшн" ХХК-тай гэрээ байгуулагдсан.	
Зорилт 5.2. Агаар, хөрс, орчны бохирдлыг бууруулж, эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэн, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.							
11	5.2.1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран хяналт тавих.	-	Хяналт тавих ААНБ, тоо	18	28	Дүүргийн Засаг даргын А/670 дугаар захирамжаар түгээмэл тархацтай ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 28 аж ахуйн нэгж байгууллагуудад 11 дүгээр сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 25-ны өдрийн хооронд мэргэжлийн байгууллагуудтай хамтран хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан. Тус ажлын хүрээнд 17 хайрга дайрга олборлогч байгууллага, найрамдлын шаврын ордоны тоосгоны 4 үйлдвэрүүдэд хяналт шалгалтыг хийж, илэрсэн зөрчлийг холбогдох дараагийн шатны байгууллагад шилжүүлэн хуулийн дагуу арга хэмжээ авч ажилласан.	100

ХОЁРДУГААР ХЭСЭГ

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГСАЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

№	Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	Төсөв /сая төгрөг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	**Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/**	
ЗОРИЛГО 9. ИННОВАЦ, ГАРААНЫ БИЗНЕС, ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИН, ХӨДӨӨ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, БОРЛУУЛАЛТЫН СҮЛЖЭЭГ ХӨГЖҮҮЛЖ, ИРГЭДИЙГ БАТАЛГААТ ХҮНСЭЭР ХАНГАНА.							
Зорилт 9.1. Өрхийн үйлдвэрлэл, жижиг бизнес, эрхлэгч, гар урлаачдыг дэмжих төвийг бүс бүрт байгуулна.							
12	9.1.12.Жишиг автобусны буудал байгуулах.	630,0 Дүүргийн төсөв	Байгуулсан цэгийн тоо	-	15	Нийслэл орон нутгийн хөгжлийн сангийн 389,7 сая төгрөгийн санхүүжилтээр 22, 32, 33, 34 дүгээр хороодын 4 байршилд дулаан автобусны буудлыг шинээр байгуулсан. Дүүргийн төсвийн 1.5 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 1, 2, 8, 9, 11, 18, 19, 20, 22, 24, 25, 33, 36, 27 дугаар хорооны 2 байршил нийт 14 хорооны 15 байршилд жишиг автобусны буудлыг шинээр суурилуулах ажлыг Эс би жи глобал" ХХК гүйцэтгэн бүрэн ашиглалтад оруулсан.	100
Зорилт 17.6. Авто замуудыг сайжруулж, нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлэн гэр хорооллыг орон сууцжуулах, байгальд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй дэвшилтэт технологи шингэсэн хувийн сууцны болон орон сууцны хороолол болгон хөгжүүлнэ.							
13	17.6.1.Орон сууцны дулаан алдагдлыг бууруулах, гадна дулаалга, дээврийн засварын ажлыг гүйцэтгэх.	2,000,0 Улсын төсөв	Ажлын явц, хувь	80%	100%	Улсын төсвийн 1,9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 27, 29 дүгээр хороодод орон сууцны гадна фасад засварын ажлын тендерт Төрөлхмөрөн ХХК шалгарч, 8 хорооны 10 блок орон сууцны байрны гадна	100

						фасад дулаалгын ажлыг хийж гүйцэтгэсэн. Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн 250,0 сая төгрөгийн санхүүжилтээр 6 дугаар хорооны 30, 31 дүгээр байрны дээвэр засварын ажлыг Эс Эм Жи Ти ХХК хийж гүйцэтгэсэн. Дүүргийн төсвийн 875,0 сая төгрөгийн санхүүжилтээр 20 дугаар хорооны 2, 6, 10, 73 дугаар байрны гадна фасад дулаалах ажлыг шинээр хийж гүйцэтгэн ашиглалтад оруулсан.	
14	17.6.2 Нийтийн зориулалттай орон сууцны байруудын газар хөдлөлтөд тэсвэртэй байдлын үнэлгээ хийлгэх	50,0 Дүүргийн төсөв	Ажлын явц, хувь	0	100%	Гамшгийн эрсдлийг бууруулах сангийн 10,7 сая төгрөгийн санхүүжилтээр 19 дүгээр хорооны 10-58 дугаар байрны газар хөдлөлтөд тэсвэртэй байдлын үнэлгээг "ИМТЕЛЛЕКТ ТОВЕР" ХХК хийж гүйцэтгэн дүгнэлтийг Сууц өмчлөгчдийн холбоонд хүргүүлсэн.	100
15	17.6.3 6 дугаар хорооны 30,31 дүгээр байрны орцны засварын ажил хийлгэх	150,0 Нийслэлийн төсөв	Ажлын явц, хувь	0	70%	Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн 135,0 сая төгрөгийн санхүүжилтээр 6 дугаар хорооны 30, 31 дүгээр байрнуудын орцны засварын ажлын сонгон шалгаруулалтыг зарласан.	70
16	17.6.4.Үерийн хамгаалалтын далан, ус зайлуулах суваг барих /11, 29, 32 дугаар хороо/	Дүүргийн төсөв, 5.341,0	Далан, сувгийн ажлын явц, км	0%	100%	Дүүргийн төсвийн хөрөнгөөр 11 дүгээр хорооны Амины орон сууцнаас Овоотын 6 дугаар гудамжинд хийгдэх 560 уртааш метр талбайд үерийн хамгаалалтын далан суваг	100

						барих ажлыг “Төрөлх мөрөн” ХХК хийж гүйцэтгэн ашиглалтад оруулсан. Нийслэлийн орон нутгийн сангийн 224,0 сая төгрөгийн санхүүжилтээр 29 дүгээр хорооны үерийн ус зайлуулах 241 уртааш метр хоолойг шинээр суурилуулж ашиглалтад оруулсан. Дүүргийн төсвийн 12,0 сая төгрөгийн санхүүжилтээр 32 дугаар хорооны Эмээлт гудамжид 12,9 км үерийн хамгаалтын далан суваг барих ажлын зураг төсвийг Гидросоружене ХХК хийж гүйцэтгэсэн.	
17	17.6.5. Улс, Нийслэл, Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хороодын гудамж дундах хатуу хучилттай авто замын ажлуудыг хийж гүйцэтгэх /5, 6, 9, 10, 11, 18, 25, 26, 27, 35, 39, 43 дугаар хороод/	5,256.9 Улс, Нийслэлийн төсөв, 7,585.2 Дүүргийн төсөв	Ашиглалтад оруулах авто зам, км	40%	100%	Улс, Нийслэл, Дүүргийн төсвийн 6.6 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 5, 6 дугаар хорооны Хүүхэд залуучуудын театрын төв зам дагуух хатуу хучилттай авто замын ажлыг “Баян өлзийт зам” ХХК хийж гйүцэтгэсэн. 10, 25 дугаар хорооны нутаг дэвсгэр Баянхошууны эцсийн буудлаас хойш үргэлжлэх 3.0 км авто замын ажлыг “Алтай рөүд” ХХК-иуд хийж гүйцэтгэн 70 хувийн хэрэгжилттэй. Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 9,6 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 35, 39, 43 дугаар хороодод баригдах хатуу хучилттай 4,5 км авто замын	100

						ажлыг “Экспресс зам” ХХК, “МАЗ” ХХК-ууд хийж гүйцэтгэн 70 хувийн хэрэгжилттэй. Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 340,0 сая төгрөгийн санхүүжилтээр 9 дүгээр хорооны 151 дүгээр сургуулийн 0,3 км авто замыг “Гоц тех инженеринг” ХХК хийж гүйцэтгэн ашиглалтад оруулсан. Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 708,0 сая төгрөгийн санхүүжилтээр 26 дугаар хорооны 152 дугаар сургуулийн 0,6 км хатуу хучилттай автозамыг “Бумбат даваа” ХХК хийж гүйцэтгэн ашиглалтад оруулсан.	
18	17.6.6. 1 дүгээр хорооллын арын холбоос авто зам, замын байгууламжийн ажлыг эхлүүлэх.	4,000.0 Нийслэлийн төсөв	Авто замын ажлын явц, хувь	30%	70%	Өнөр хорооллын арын холбоос авто зам, замын байгууламж Толгойтын авто замыг Ард аюушийн өргөн чөлөөтэй холбох 3.6 км хатуу хучилттай авто замын ажлыг “МАЗ” ХХК гүйцэтгэн 70 хувийн хэрэгжилттэй, 4 гүүрэн байгууламжийн ажил бүрэн хийгдэж дууссан.	70
19	17.6.7.Баянхошуу дэд төвийн бүтээн байгуулалтын ажлыг бүрэн дуусгах.	-	Ажлын гүйцэтгэл, хувь	90%	100%	Баянхошуу дэд төвийн хүрээнд орлогод нийцсэн орон сууцны туршилт, 20 айлын орон сууцны барилгын ажил дуусч, орон сууцны барилгын ажил үргэлжлэн эхэлсэн	100

20	17.6.8.Толгойт дэд төвийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх.	-	Ажлын гүйцэтгэл, хувь	30	80	Толгойт дэд төвийн бүтээн байгуулалтын ажлын хүрээнд 487 нэгж талбарын 544 өрх өртөж, 406 айл өрхийг бүрэн чөлөөлсөн. Толгойт дэд төвийн инженерийн шугам сүлжээний нөлөөлөлд өртсөн иргэдтэй хийх зөвшилцлийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Дэд төвийн үерийн хамгаалалтын барилга байгууламжийн ажил, сургалтын төвийн барилга байгууламжийн ажил бүрэн хийгдэж дууссан.	80
21	17.6.9. Хилчин хотхоны инженерийн шугам сүлжээний ажлыг дуусгах /30 дугаар хороо/.	2,800.0 Улсын төсөв	Үйл ажиллагаа ны хэрэгжилт, хувь	70%	100%	Улсын төсвийн 2,7 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 2023-2024 онд он дамжин хэрэгжих 30 дугаар хороо Хилчин хотхоны дулааны шугам барих ажлын гүйцэтгэгчээр "И Жи Өү" ХХК шалгарч, барилгын ажлыг төлөвлөсөн хугацаанаас өмнө хийж гүйцэтгэн ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн.	100
22	17.6.10. Дүүргийн 1, 2, 3, 7, 13, 21, 22, 25, 26, 27, 32, 33, 34, 36, 41 дүгээр хороодын гудамж талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх.	2.725.1 ДОНХС, дүүргийн төсөв	Ашиглалт ад орох гэрэлтүүл эг, тоо	22978	23778	Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн 452,0 сая төгрөгийн санхүүжилтээр 2, 33, 34, 42 дугаар хороодын нийтийн эзэмшлийн гудамж талбайд 128 ширхэг гэрэлтүүлгийн шинээр суурилуулах ажлыг "Дулаахан жаргалан" ХХК хийж гүйцэтгэсэн. Дүүргийн төсвийн 1,9 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 1, 2, 3, 7, 13, 18, 21, 22, 24, 25, 26, 27, 32, 33, 34,	100

						36, 41 дүгээр хороодын нийтийн эзэмшлийн гудамж талбайд 416 ширхэг гэрэлтүүлэг, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 800,0 сая төгрөгийн санхүүжилтээр 1, 22, 33, 41 дүгээр хороодын нийтийн эзэмшлийн гудамж талбайд 595 ширхэг гэрэлтүүлгийг шинээр суурилуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. 2024 онд 18 хорооны нутаг дэвсгэрийн нийтийн эзэмшлийн гудамж талбайд 1139 ширхэг гэрэлтүүлтгийг шинээр суурилуулан бүрэн ашиглалтад оруулж, нийтийн эзэмшлийн 23778 ширхэг гэрэлтүүлэг 98,9 хувийн асалттай.	
	Нийт дундаж хувь						**90.9**

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН

ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН ХЭЛТЭС

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
8 дугаар хавсралт

ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН ХЭЛТСИЙН ДАРГА Ж.НЯМХҮҮГИЙН 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ТОХИЖИЛТ НИЙТИЙН АЖ АХУЙН ДАРГА Ж.НЯМХҮҮГИЙН 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр:Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар
Нэгжийн нэр: Тохижилт нийтийн аж ахуйн хэлтэс

1. **Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/д	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин	Нийт (70 оноо)
1	2	3	4
1.	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	90.9.	63.6

2. **Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Удирдлагын академийн захирлын А/930 тоот тушаалаар төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад хамрагдаж, R1577дугаартай сертификат гардан авсан.	100%	13.0.
2.	Засаг даргын Тамгын газраас хамруулж буй 2 дугаар ээлжийн Монгол бичгийн сургалтад хамрагдсан.		
Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо			13.0.

3. **Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ**

Д/д	Үзүүлэлт	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Хандлага, ёс зүй	10.0
2.	Удирдан зохион байгуулах	10.0
3.	Асуудал шийдвэрлэх	13.0
4.	Манлайлах	15.0
5.	Багаар ажиллах	12.0
6.	Харилцаа	10.0
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)		~~11.4~~

7.	Мэргэжлийн ур чадвар 1.	
8.	Мэргэжлийн ур чадвар 2.	
9.	Мэргэжлийн ур чадвар 3.	
Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо		11,7

4. **Гүйцэтгэлийн үнэлгээ**

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт	63.6
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	13.0
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ	11.7
4.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт	—
Нийт оноо		88,3

Үнэлгээ өгсөн:

Засаг даргын Тамгын газрын дарга
(албан тушаал)

..... /Д.Төмөрбаатар/
(гарын үсэг)

Төсвийн шууд захирагч

2024.12.18.
.....
(огноо)

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:

ТНААХ-ийн дарга
(албан тушаал)

..... /Ж.Нямхүү/
(гарын үсэг) *(албан хаагчийн нэр)*

Нэгжийн дарга:

(огноо) 2024.12.18.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
7 дугаар хавсралт

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХҮНС, ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2.4	Хороодын албан хаагчдын ажлын гүйцэтгэл, ур чадварыг сайжруулах ажлын хүрээнд хагас, бүтэн жилээр сургалт зохион байгуулах.	14	Зохион байгуулсан сургалтын тоо	0	12	30	Хороодын төрийн албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор 2024 оны 01 дүгээр сарын 03, 04-ний өдөр Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс, Архивын хэлтэстэй хамтран 2 өдрийн сургалтыг Тамгын газрын хэлтэс, тасгийн ахлах мэргэжилтэн, хороодын Зохион байгуулагч, Нийгмийн ажилтан нарыг хамруулсан сургалтыг зохион байгуулж ажиллалаа. Хороодын албан хаагчдыг чадваржуулах сургалтыг 2024 оны 09 дүгээр сарын 20, 21-ны өдрүүдэд Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ-ын ТЗУХ, ХШҮХ-тэй хамтран 43 хорооны Зохион байгуулагч нарын дунд	100%

							багийн зохион байгуулалтайгаар 3 үе шаттай сургалт, арга хэмжээг зохион байгуулав. Тус арга хэмжээ нь Хороодын албан хаагч нарын мэдлэг чадварыг сайжруулах харилцан туршлага судлах зорилгоор Засаг даргын А болон Б захирамж, шуурхай үүрэг даалгаврын бүрдэл, тогтоол шийдвэрийн биелэлт зэрэг анхан шатны нэгжид зайлшгүй хөтлөгдөх баримт бичгийн стандарт түүний хэрэгжилтийг хангуулах зорилгоор харилцан туршлага судлах арга зүйг олгох сургалтыг хамтран хэрэгжүүлэв.	
2.5.	Дүүргийн нутаг дэвсгэрт Монгол гэр дуулаалгын "ЧИП" төслийг 2024 онд хэрэгжүүлж ажиллах	150	Төсөлд хамрагдсан өрхийн тоо	30	45	45	Дүүргийн Засаг даргын 2024 оны А/57 дугаар захирамжаар Нэгдсэн Үндэстний байгууллагаас дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран хэрэгжүүлж буй Монгол гэр дулаалгын "ЧИП" төсөлд 2024 онд дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас 150 сая төгрөг төсөвлөж зорилтот бүлгийн 90 өрхийг хамруулсан.	100%
2.6.	Дүүргийн Засаг даргын захирамж, Засаг даргын Тамгын газрын даргын тушаалын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	-	Хяналт-шинжилгээ, үнэлгээний хувь	100	50	100	2024 оны онд дүүргийн Засаг даргын А захирамж 647, Б захирамж 83, Засаг даргын Тамгын газрын А тушаал 147, Б тушаал 315 гарсан байна. Захирамж тушаалын хэрэгжилтэд хяналт–шинжилгээ, үнэлгээ хийж ажилласан. Хэрэгжилтийн	100%

							дундаж хувь 93,5 байна.	
2.7.	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын ажлын цаг ашиглалтад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	-	Зохион байгуулсан хяналт шалгалтын тоо	1	6	12	Дүүргийн Засаг даргын 2023 оны А/06 дугаар захирамжийн хүрээнд ДЗДТГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу ажлын цаг ашиглалтад хяналт шалгалтын ажлыг 2024 оны 01,02,03 дугаар саруудад хийж ажилласан. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын ажлын цаг ашиглалтад сард 2 удаа хуваарийн дагуу хяналт тавьж ажилласан. Хороодын албан хаагчдын ажлын цаг ашиглалтыг сайжруулах зорилгоор харицсан 18,29,38 дугаар хороодын цаг ашиглалтад 4 удаа хяналт тавьж ажилласан.	100%
2.8.	Дүүргийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагууд болон хороодын 2024 оны үйл ажиллагаа, гүйцэтгэлийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах	3	Хяналт-шалгалтад хамрагдсан байгууллагын тоо	54	-	54	Дүүргийн Засаг даргын 2024 оны А/690 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулагдаж дүүргийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа 14 байгууллага, 14 хорооны 2024 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, үр дүг дүүргийн Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулсан.	100%
ГУРАВДУГААР ХЭСЭГ. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ								
3. Нийслэл, дүүргийн удирдлагуудаас өгсөн цаг үеийн холбогдолтой үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулж ажиллана								
3.1	Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын Дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний 2024 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулж,	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	50	100	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Дотоод хяналтын төлөвлөгөөг 6 бүлэг 19 заалттай боловсруулж батлуулсан.	100%

	хэрэгжилтийг хангаж ажиллах							
3.2	Дүүргийн Засаг даргын 2023 оны А/06 дугаар захирамжаар батлагдсан “Дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам”-ын хэрэгжилтийг хангаж ажиллах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	50	100	Журмын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Дотоод хяналтын ажлын хүрээнд Тамгын газрын албан хаагчдын ажлын цаг ашиглалтад 5 удаа хяналт тавьж ажилласан. Албан хаагчдын ажлын цаг ашиглалтын хяналтын хуудсыг 03, 04 дүгээр саруудад бөглүүлэн авч, нэгдсэн дүгнэлтийг Засаг даргын Тамгын газрын даргад танилцуулсан. Ээлжит УИХ-ын болон орон нутгийн сонгуультай холбоотой энэ ажил зогссон.	100%
3.3	Дүүргийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг зохион байгуулах, өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, үр дүнд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж танилцуулах	-	Зохион байгуулсан шуурхай зөвлөгөөний тоо	33	16	17	Дүүргийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг 24 удаа зохион байгуулж 321 үүрэг даалгаврын хэрэгжилтийг нэгтгэж ажилласан. Биелэлтийн дундаж хувь 71,6% байна.	100%
3.4.	Хороодын Засаг дарга нарын шуурхай хуралдааныг зохион байгуулах, хуралдаанаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, үр дүнд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж танилцуулах	-	Зохион байгуулсан шуурхай зөвлөгөөний тоо	33	16	17	Хороодын Засаг дарга нарын шуурхай хуралдааныг нийт 24 удаа зохион байгуулсанаас танхимаар 19, цахимаар 5 удаа зохион байгуулж 200 үүрэг даалгаврын хэрэгжилтийг нэгтгэж ажилласан. Биелэлтийн дундаж хувь 81,5% байна.	100%
3.5.	Дүүргийн хэлтэс, тасгийн дарга нарын шуурхай хуралдааныг зохион байгуулах, хуралдаанаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, үр дүнд хяналт-	-	Зохион байгуулсан шуурхай зөвлөгөөний тоо	19	10	10	Хэлтэс тасгийн дарга нарын 18 удаагийн шуурхай хуралдаан зохион байгуулагдаж, давхардсан тоогоор 301 үүрэг даалгавар өгөгдөж, хэрэгжилт 69,0 хувьтай байна.	70%

	шинжилгээ үнэлгээ хийж танилцуулах							
3.6.	Дээд газраас ирүүлсэн тогтоол шийдвэрийн хэргэжилтэнд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх	-	Хяналт-шинжилгээ, үнэлгээний хувь	94,6	70	95	Дээд газрын тогтоол шийдвэрийн эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон холбогдох бусад дээд шатны байгууллагаас ирүүлсэн 46 тогтоол шийдвэрийн 102 заалтад хяналт шинжилгээ, үнэлгээ хийж дундаж хувь 92,5% байна. Дүүргийн ИТХ-ын 12 тогтоолын 27 заалтад хяналт шинжилгээ үнэлгээ хийж ажилласан. Биелэлтийн дундаж хувь 94,8% байна.	100%
3.7.	Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	-	Хяналт-шинжилгээ, үнэлгээний хувь	95,9	70	96,0	2023 оны жилийн эцсийн үйл ажиллагааны шалгалтаар Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар "Бүрэн хангалттай" гэж дүгнэгдсэн ба Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зөвлөмж ирүүлээгүй.	100%
3.8.	Гадаад болон олон улсын төсөл хөтөлбөрөөр санхүүжиж хэрэгжих хөрөнгө оруулалтын ажлын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	-	Хяналт-шинжилгээ, үнэлгээний хувь	30	30	50	Гадаад болон олон улсын төсөл хөтөлбөрөөр 2024 онд 5 төсөл арга хэмжээ хэрэгжиж байна. Үүнд: 1.Монголын Мянганы Сорилтын сангийн хоёр дахь гэрээний санхүүжилтээр хэрэгжиж буй "Хаягдал ус дахин боловсруулах" төслийн хүрээнд 20, 32 дугаар хорооны нутаг дэвсгэрт байгуулж буй "Ус дахин боловсруулах үйлдвэр"-ийн барилгын ажлын гүйцэтгэл 80%, шугам татах ажлын	70%

							гүйцэтгэл 50%-тай явагдаж байна. Гүйцэтгэгч байгууллагаар "М-Си-Эс Проперти" ХХК ажиллаж байна. 2. Байгаль орчны яам, Бүгд Найрамдах Солонгос улсын хүрээлэн буй орчны судлалын төвийн буцалтгүй тусламжаар Улаанбаатар хотын гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах, цөлжилтөөс урьдчилан сэргийлэх төслийн хүрээнд 24-р хорооны 746 өрхөд ариун цэврийн байгууламж суурилуулсан. Дээрх байгууламжын бохир лаг цуглуулах барилгын ажлыг 40 дүгээр хороонд 1300м2 газрыг шийдвэрлэсэн ч одоогоор барилгын ажил эхлээгүй байна. 3. "Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр" төслөөс дэлхийн банкны 102,7 сая долларын санхүүжилтээр Өнөр хорооллын 12-17-р хороонд 2,8 км, Таван шарын уулзвараас Баянхошуу тойрог хүртэл 5,5 км авто замын инженерийн цогц шийдэлтэй бүтээн байгуулалтыг 2025-2026 онд хийж хэрэгжүүлэхээр гэрээ байгуулагдаж, гүйцэтгэгчээр "Макс роуд" ХХК-ын шалгаран 2025 оны 4-р сараас ажил эхлэхээр төлөвлөж байна. 4. Нэгдсэн Үндэстний байгууллагын Хабитат төслөөр 2024-2025 онд хэрэгжүүлэх 4, 5, 26, 27 дугаар хороодын нутаг дэвсгэрт нийт 2.2 км урттай, 15	

							метрийн өргөнтэй үерийн хамгаалалтын далан суваг барих, моджуулах, өвлийн цагт халиа үүсэхээс урьдчилан сэргийлэх дэд бүтэц болон оршин суугч иргэдийг чадавхжуулах, ариун цэврийн байгууламжийг барих ажлын зураг төслийг "Усны эрчим" ХХК хийж гүйцэтгэсэн. Үерийн далан суваг барих ажлыг "Тех монтаж" ХХК шалгарч, Багц 1 дүгээр ажил буюу "Хөв цөөрөм" байгуулах ажлыг гүйцэтгэж байна. Гүйцэтгэл 20%-тай байна. 5. Тайваны хүүхэд гэр бүлийг дэмжих сангийн хөрөнгөөр ундны усан хангамж сайжруулах төслийн хүрээнд 32 дугаар хорооны нутаг дэвсгэрт ус түгээх байр барих ажлыг зохион байгуулж 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр Улсын комисс ажиллаж, үүрэг даалгавар өгч ажилласан. 6 НҮБ-ын хөрөнгө оруулалтаар	
3.9.	Зогссон болон удааширсан бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах	-	Хяналт хийсэн ажлын тоо	-	1	1	Дүүргийн хэмжээнд 2012 оноос зогссон болон удааширсан хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын 47 байршилд 2024 оны 04 дүгээр сарын 20-ноос 05 дугаар сарын 20-ыг хүртэл хяналт шалгалтын ажил зохион байгуулж ажилласан. Хөрөнгө оруулалтын ажлуудын удааширсан, зогссон шалтгаан нөхцлийг тодруулахад санхүүжилтгүйн улмаас зогссон 36 ажил, бусад шалтгаанаар зогссон 11 ажил байна. 2024 оны	100%

							09 дүгээр сарын 09-ны өдөр барилгын ажил гүйцэтгэгч 41 байгууллагад мэдэгдэл хүргэснээс 17 байгууллагын удирдлагуудтай дүүргийн Засаг дарга уулзаж зогссон, удааширсан ажлыг цааш үргэлжлүүлэн явуулах, ашиглалтад оруулах талаар уулзалт зохион байгуулж ажилласан. 2024 оны 11 дүгээр сарын 20-ны байдлаар 6 хөрөнгө оруулалтын ажил хэвийн үргэлжилж 11 ажил ашиглалтад 100% орсон байна.	
3.10.	2023-2024 онд хийгдэх бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах	1	Хяналт хийсэн ажлын тоо	-	-	1	2023-2024 онд дүүргийн нутаг дэвсгэрт хийгдсэн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын 99 ажлын гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж гүйцэтгэсэн. Үүнд: 1. Улсын төсвийн хөрөнгөөр 12 ажил гүйцэтгэсэнээс 2 ажил 50%, 1 ажил 10% 9 ажил 100%-ийн гүйцэтгэлтэй байна. 2. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 9 ажил гүйцэтгэсэнээс 1 ажил 10% 2 ажил 40%, 1 ажил 60%, 5 ажил 100%-ийн гүйцэтгэлтэй байна. 3. НОНХСХөрөнгөөр 21 ажил гүйцэтгэсэнээс 1 ажил 80%, 1 ажил 20%, 19 ажил 100%-ийн гүйцэтгэлтэй байна. 4. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 37 ажил гүйцэтгэсэнээс 1 ажил эхлээгүй, 1 ажил 30%, 1 ажил 50%, 3 ажил 80%, 31 ажил 100%-ийн гүйцэтгэлтэй байна. 5. ДОНХСХөрөнгөөр 20 ажил гүйцэтгэсэнээс 1 ажил эхлээгүй,	100%

							1 ажил 40%, 1 ажил 80% 17 100%-ийн гүйцэтгэлтэй байна.	
3.11.	Дүүргийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн, хороодын Засаг дарга нарын шуурхай хуралдаан, Хэлтэс тасгийн дарга нарын шуурхай хуралдаан зохион байгуулах журмыг шинэчлэн боловсруулж, батлуулах	-	Батлуулсан журмын тоо	-	3	-	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны А/40, А/41, дүгээр тушаалаар хороодын Засаг дарга нарын шуурхай хуралдаан, Хэлтэс тасгийн дарга нарын шуурхай хуралдаан зохион байгуулах журмыг шинэчлэн боловсруулж, батлуулсан.	100%
ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ								
4.1	Хэлтэс, албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулах, тайлагнах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	50	100	Хэлтсийн болон төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж батлуулсан.	100%
4.2.	Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх	-	Дүгнүүлэх төрийн албан хаагч, тоо	4	4	4	Хэлтсийн албан хаагчид 2024 онд хагас, бүтэн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг тогтоосон хугацаанд тайлагнаж, үнэлүүлсэн.	100%
4.3.	Төрийн албан хаагчдын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцын ярилцлагыг зохион байгуулах	-	Ярилцлагад хамрагдах албан хаагчийн тоо	4	4	4	Засгийн газрын 98 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын дагуу 1, 3 дугаар улиралд ярилцлага хийсэн.	100%
4.4	Хэлтсийн шуурхайг зохион байгуулж үүрэг даалгаврын биелэлтийг хангуулж, тэмдэглэл хөтлөх	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	85	70	90	Хэлтсийн шуурхайг 11 удаа зохион байгуулж цаг үеийн холбогдолтой болон шуурхай шийдвэрлэх асуудлыг хэлэлцсэн.	100%
4.5.	Хэлтсийн дарга, ажилтнуудын ээлжийн амралтын саналыг боловсруулан ТЗУХ-т	-	Хүргүүлэх санал, тоо	1	1	-	Хэлтсийн албан хаагчдын 2024 оны ээлжийн амралтын саналыг тогтоосон хугацаанд гаргаж ТЗУХ-д хүргүүлсэн.	100%

	хүргэх							
4.6.	Цаг үеийн холбогдолтой ажлын хуваарь гаргаж танилцуулах, мэдээлэл хүргэх	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	50	100	2024 онд цаг үеийн холбогдолтой ажлаар 1 удаа хуваарь гаргаж ажилласан.	100%
4.7.	Хэлтэст ирсэн албан бичгийг бүртгэн, хариутай бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавьж, мэдээлэх	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	50	100	2024 онд өргедөл 3, явсан бичиг 21, 72 бичиг ирсэнийг хугацаанд нь шийдвэрлэж ажилласан. Шийдвэрлэлтийн зөрчилгүй.	100%
4.8.	2023 оны архивын материалыг цэгцлэн хүлээлгэн өгөх	-	Архивын нэгжийн тоо	6	11	-	Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2023 оны 11 баримтыг архивын нэгж үүсгэн Архивын хэлтэст хүлээлгэж өгсөн.	100%
Дундаж хувь								**97,2%**

Тайланг үнэлсэн: ***Төсвийн шууд захирагч***

Засаг даргын Тамгын газрын дарга ..... /Д.Төмөрбаатар/
(албан тушаал) *(гарын үсэг)* *(огноо)*

Тэмдэг .....

Тайлагнасан: ***Нэгжийн дарга***

Хяналт-шинжилгээ
үнэлгээний хэлтсийн дарга ..... /С.Туулмаа/
(албан тушаал) *(гарын үсэг)* *(огнор)*

2024.12.18

126

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
8 дугаар хавсралт

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА СҮРЭНЧУЛУУНЫ ТУУЛМААГИЙН 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА СҮРЭНЧУЛУУНЫ ТУУЛМААГИЙН 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар

Нэгжийн нэр: Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин	Нийт оноо (70 оноо)
1	2	3	4
	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	97,2	68,0

2.Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Арга хэмжээ 1.2024.01.21-2024.01.29 “Менежмент ба ур чадвар” ТББ-аас БНТУ-д зохион байгуулсан “ОУ-ын менежментийн тогтолцооны стандартыг нэвтрүүлсэн туршлага солилцох “CREATIVE TRAINING” 7 өдрийн сургалтад хамрагдсан.	100	11.0
2.	Арга хэмжээ 2.2024.05.14-ний өдөр “Хяналт шинжилгээ, үнэлгээний нэгжийн ажлын хариуцлага, үйл ажиллагааны уялдааг сайжруулах нь” сургалт – НЗДТГ	100	11.0
3.	Арга хэмжээ 3.2024.04.09-ний өдөр НҮБ-аас зохион байгуулсан МАФ шинэ төслийн сургалт	100	11.0

11.0

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ

Д/д	Үзүүлэлт	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	11.0
2.	Удирдан зохион байгуулах	11.0
3.	Асуудал шийдвэрлэх	10.0

4.	Манлайлах	12.6
5.	Багаар ажиллах	13.0
6.	Харилцаа	12.0
Дундаж оноо		11.4

5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт)*	68.0
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт *(Төсвийн шууд захирагчийн үнэлгээ)*	11.0
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Төсвийн шууд захирагчийн үнэлгээ)*	11.4
4.	Үнэлгээний онооонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)*	—
Нийт оноо =		90.4

Үнэлгээ өгсөн: ***Төсвийн шууд захирагч***

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга ..... Д.Төмөрбаатар

(албан тушаал) *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2024.12.18 ..... *(огноо)*

Үнэлгээтэй танилцаж зөвшөөрсөн: ***Нэгжийн дарга:***

ХШҮХ-ийн дарга ..... С.Туулмаа

(албан тушаал) *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2024.12.09 ..... *(огноо)*

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
7 дугаар хавсралт

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ

2024 оны 11 дүгээр сарын 29

Д/д	Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэт-гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ							
1.	Арга хэмжээ 1.1. Дүүргийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлуудын худалдан авах ажиллагааг зохион байгуулахтай холбоотой бэлтгэл ажлыг хангах, тайлагнах	22.2 тэрбум	Хэрэгжих төсөл арга хэмжээ, тоо	0	106	Дүүргийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 хэрэгжүүлэхээр батлагдсан 150 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны бэлтгэл ажлыг худалдан авах ажиллагааг зохион байгуулснаас дууссан 108, ажил гүйцэтгэж буй 18, тендер зарласан 9, дахин тендер зарлах 10, зураг төсөв хийгдэж байгаа 2, хасах саналтай 3 ажил байна.	90.0
2.	Арга хэмжээ 1.2. “Улаанбаатар хотын гэр хорооллын ариун цэврийн байгууламжийн асуудлыг шийдвэрлэх” төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтарч ажиллах	-	Төслийн хэрэгжилт, хувь	10	50	Шинжлэх ухааны академийн санаачилгаар Солонгос улсын 5,5ам/долларын буцалтгүй тусламжаар хөрсний бохирлыг бууруулах зорилго бүхий “Улаанбаатар хотын гэр хорооллын ариун цэврийн байгууламжийн асуудлыг шийдвэрлэх төсөл”-ийг 2022-2025 онд дүүрэгт хэрэгжүүлэхээр болсон. Төслийн хүрээнд урьдчилан цэвэрлэх байгууламж 1, бохирын машин 2, 740 орчим айлын 00-ыг шинэчлэх ажил хийгдэх юм. Барилга байгууламж барих газрыг нийслэлийн ЗД-ын 2023 оны А/678 тоот захирамжаар	90.0

1	2	3	4	5	6	7	8
						шийдвэрлэсэн ч, ХБХГ-ын саналаар байршлыг дахин өөрчилж, 2023 оны 10 дугаар сарын 17-ны А/217 дугаар захирамжаар тус дүүргийн 40 дүгээр хороонд 1300м2 газар болон холбогдох бичиг баримтыг шийдвэрлэсэн. Ариун цэврийн байгууламжийн барилгын суурийн ажлыг эхэлж байна. 24 хороонд нийт 746 айлын нүхэн жорлонг соруулдаг ариун цэврийн байгууламжаар шинэчлэх ажил дууссан.	
ХОЁРДУГААР ХЭСЭГ. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ							
1.	Арга хэмжээ 2.1. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн явц, үр дүнг тооцож, тайлагнах	-	Тайлагнах давтамж, тоо	0	2	Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 1 дүгээр улирал бүр НЗДТГ-ын ХШҮХ-т ERP хаягаар хүргүүлсэн.	90.0
2.	Арга хэмжээ 2.2. Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний явц, үр дүнг тооцож тайлагнах	-	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувь	0	95	Нийслэлийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний дүүрэгт хамааралтай 17 зааалтын биелэлтийг гаргаж НЗДТГ-ын ХШҮХ-т ERP хаягаар хүргүүлсэн.	90.0
3.	Арга хэмжээ 2.3. Дүүргийн засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж, хагас, бүтэн жилийн байдлаар биелэлтийг тооцож, тайлагнах	-	Хөтөлбөрийн хэрэгжилт, хувь	77.3	95	Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хагас жилийн биелэлтийг 81.9 хувьтай тооцож 06 дугаар сарын 25-ны өдрийн 03/1886 тоот албан бичгээр ДИТХ-ын Ажлын албанд хүргүүлсэн. Жилийн эцсийн байдлаар нэгтгэж байна.	70.0

1	2	3	4	5	6	7	8
4.	Арга хэмжээ 2.4. Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, батлуулах	-	Батлуулах төлөвлөгөө, тоо	0	1	Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 201 заалттай боловсруулж Засаг даргын 2024 оны А/04 дүгээр захирамжаар батлуулсан.	100.0
5.	Арга хэмжээ 2.5. Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр нэгтгэн хэрэгжилтийг тооцох	-	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувь	0	95	Арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг 2024 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэж гаргахаар хэлтэс, тасгуудаас биелэлт авч байна.	30.0
6.	Арга хэмжээ 2.6. Улс, нийслэл, НОНХС-аас дүүрэгт эрх шилжин хэрэгжих төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахтай холбоотой бэлтгэл ажлыг хангах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	0	100	2024 онд нийслэлийн Засаг даргын 2024 оны А/234, 237, 238, 308, 359, 509, 582, 625, 933, 1308, 1310, 1439, 1446, 1468, 1476, 1501, 1530 дугаар захирамжаар эрх шилжин ирсэн нийт 42 төсөл, арга хэмжээнээс дууссан 15, ажил гүйцэтгэх шатанд 14, тендер зарласан 10, дахин зарлах шатанд 2, хасах саналтай 1 ажил байна.	70.0
7.	Арга хэмжээ 2.7. Тухайн онд болон дараа онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын зураг, төсөв боловсруулах ажлыг зохион байгуулах	2.1 тэрбум	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	0	100	Дүүргийн хэмжээнд 2024 онд улсын төсвөөс 1, нийслэлийн төсөв 22, НОНХС 19, дүүргийн төсөв 91, ДОНХС 59 нийт 192 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж байгаагаас 188 төсөл, арга хэмжээний зураг, төсөв хийлгэх, техникийн тодорхойлолт боловсруулж батлуулах ажлыг хийж худалдан авах ажиллагааны бэлтгэл ажлыг хангасан. 4 төсөл, арга хэмжээний зураг, төсөв хийгдэх явцад удааширснаас шалтгаалан хасах саналтай байна.	90.0

1	2	3	4	5	6	7	8
8.	Арга хэмжээ 2.8. Улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлыг төлөвлөх, санал боловсруулах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	0	100	Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд тусгуулах хөрөнгө оруулалтын ажлын саналыг 07.24-нд, нийслэлийн 2025 оны төсөвт тусгуулах хөрөнгө оруулалтын ажлын саналыг 10.24-ний өдрийн 03/2902, 11.13-ны өдрийн 01/3120, 11.20-ны өдрийн 02/3165 тоот албан бичгээр тус тус санал хүргүүлсэн. ДОНХС-ийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх 68 ажлын жагсаалт гарган зураг төсвийг хийлгэж байна.	100.0
9.	Арга хэмжээ 2.9. Хөрөнгө оруулалтын ажлын газрын нөлөөлөлд өртсөн нэгж талбарыг нөхөх олговортой чөлөөлөх ажлыг зохион байгуулах	4.9 тэрбум	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	0	100	Дүүргийн Засаг даргын 16 удаагийн захирамжаар 63 иргэний 20420 м2 газрыг 4.3 тэрбум төгрөгийн нөхөн олговортой чөлөөлсөн.	100.0
10.	Арга хэмжээ 2.10. Шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний сонгон шалгаруулалтыг зохион байгуулах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	0	100	Шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний дагуу дүүргийн төсвөөр хэрэгжих хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах 65 удаагийн хурлыг зохион байгуулж ажилласан.	100.0
11.	Арга хэмжээ 2.11. Хөтөлбөр, төслүүдийн биелэлтийг холбогдох хэлтэс, тасгуудаас авч нэгтгэх	-	Биелэлт гаргах хөтөлбөр, төсөл, тоо	0	11	Дүүргийн ИТХ-ын тогтоолоор батлагдсан 11 төсөл, хөтөлбөрүүдийн биелэлтийг жилийн эцсийн байдлаар холбогдох хэлтэс, тасгаас авсан. ИТХ-ын Ажлын албанд хүргүүлэхээр ажиллаж байна.	90.0
12.	Арга хэмжээ 2.12. Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцын судалгааг шинэчлэж, холбогдох газарт хүргүүлж, дахин төлөвлөлтийн ажилд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	0	100	Дүүргийн хэмжээнд 8 хорооны 30 орон сууцны байр мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй байна. Судалгааг шинэчлэн гаргаад Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэст цахимаар хүргүүлсэн. 20 дугаар хороонд 2.1 га талбайд 1 давхар 11 дан байр /108 өрх/-ыг дахин төлөвлөж	90.0

1	2	3	4	5	6	7	8
						барилгажуулахаар гүйцэтгэгчээр “Тулгуур түмэн тулга” ХХК шалгарч, 16 давхар 8 блок орон сууц, 1 цэцэрлэг, үйлчилгээний төв баригдахаар төлөвлөснөөс нийт 11 байраас 5 байрыг чөлөөлж буулган, 2 орон сууцны барилгын угсралтын ажил дуусч, гадна дүүргэлтийн ажил 90 орчим хувьтай, гадна инженерийн шугам сүлжээний ажил 80 хувьтай байна. 18 дугаар хороонд төсөл хэрэгжүүлэгч “Хур алтан өргөө” ХХК нь багц 2 хүрээнд 5 байрыг буулган, барилгын ажлыг эхлүүлэн бөгөөд барилга угсралтын /зоорийн болон 1-13 дугаар давхар/ ажлын явц 60 орчим хувьтай. Уг төсөлд хөндлөнгийн хяналтыг тавих “Хяналтын хороо”-г иргэдийн төлөөллөөс 5, мэргэжлийн байгууллагын 2, нийт 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр 18 дугаар хорооны Засаг даргын захирамжаар байгуулсан. Станцын 4 дүгээр байрыг буулгах, цаашид тухайн төсөл хэрэгжүүлэхтэй хамтран ажиллах талаар шийдвэр гаргах тухайн байрны иргэдийн төлөөллийн бүрэлдэхүүнтэй “Хяналтын хороо”-г тусад нь байгуулж, хуралдаанаас гарсан шийдвэрийг НОСБ-т хүргүүлсэн. Гадна инженерийн шугам сүлжээг татах, өргөтгөх, шинээр хийх ажлын зураг төсөл батлагдсан. УДДТ-ийн барилга, цахилгааны кабель шугам, 10/0,4кВ-ын 800кВА хүчин чадалтай 2ш хуваарилах байгууламжийн барилга угсралт, тоног төхөөрөмж, 10кВ-ийн кабель шугамын угсралтын ажил бүрэн хийгдэж дууссан. Уг цахилгааны дэд станц, тоног төхөөрөмж	

1	2	3	4	5	6	7	8
						кабель шугамын угсралын ажлыг хүлээлцэх комисс 10-р сарын 30-ны өдөр НХШГ-ын Улсын комисс ажиллах болсон. 4-р байрыг буулгах ажлын гүйцэтгэгчээр "Танан цамхаг констракшн" ХХК шалгарсан. Төсөл хэрэгжүүлэгч нь иргэдтэй 2 ба 3 талт гэрээг бүрэн байгуулаагүй, 7 иргэд зөвшилцөж чадаагүй тул байрыг буулгах ажил хойшлогдон, ажил гүйцэтгэх гэрээг 4 дахь удаа сунгасан. 19-р хорооны ашиглалтын шаардлага хангахгүй 3-20 дугаар дан байрны тендер сонгон шалгаруулалтаар төслийг хэрэгжүүлэхээр "Очир бумбат констракшн" ХХК шалгарсан. 1 давхар нь үйлчилгээний талбай бүхий 1 блок 16 давхар 132 айлын орон сууцны барилгын төлөвлөлттэй. Бүртгэлээр тус байр нь нийт 26 айл өрхтэй, 21-н өрхтэй 2 ба 3 талт гэрээг байгуулж, 5 иргэний талбайг худалдан авч, оршин суугчидтай гэрээ байгуулж дууссан. Барилга буулгах, эхлүүлэх зөвшөөрлийг авч, барилгын суурийн ажлыг эхлүүлсэн.	
13.	Арга хэмжээ 2.13. Хотын хөгжлийн индексийн 2023 оны судалгааг хороодоос баталгаажуулан авч хяналт тавин, мэргэжил арга зүйгээр хангах, судалгааг мэдээллийг холбогдох газарт хүргүүлэх	-	Баталгаажуулах маягт, тоо	0	17	Бодлого, судалгаа шинжилгээний төвөөс хотын хөгжлийн индексийн мэдээллийг оруулах программ хангамжийг өөрчлөлт, шинэчлэлтийн ажлын тендерийг зарласан ч материал ирүүлсэн гүйцэтгэгч одоогоор байхгүй. Хороодын 2023 оны Хотын хөгжлийн индексийн тоон мэдээллийг /www.happycity.mn/ программд оруулах ажилд өдөр тутмын хяналтыг тавьж, дүн шинжилгээ хийж, мэргэжил арга зүйн зөвөлгөөг өгч ажиллаж байна. 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрөөс 12 дугаар сарын 27-ны өдрүүдэд анхан шатны мэдээллийн бодит байдал, уялдаа	90.0

1	2	3	4	5	6	7	8
						холбоо, чанарт үнэлгээ хийх зөвлөн туслах ажлыг Тамгын газрын даргын А/169 дүгээр тушаалаар зохион байгуулан ажиллаж байна. Программ шинэчлэл хойшилсон тул 2023 оны Хотын хөгжлийн индексийн тоон мэдээллийг /www.happycity.mn/ программд оруулж, шивэгдсэн тоон үзүүлэлтүүдийн бодит байдлыг нягтлан хянаад, холбогдох байгууллагууд руу илгээсэн. Тухайн ажил 90 орчим хувьтай хийгдэж байна.	
ГУРАВДУГААР ХЭСЭГ. ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ							
1.	Арга хэмжээ 3.1. Хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний төсөл боловсруулан батлуулах	-	Батлуулах төлөвлөгөө, тоо	0	1	Хэлтсийн төлөвлөгөөг 27 заалттай боловсруулж Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулсан.	100.0
2.	Арга хэмжээ 3.2. Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулах	-	Батлуулах төлөвлөгөө, тоо	0	3	Хэлтсийн 3 мэргэжилтний төлөвлөгөөг 1 дүгээр сард батлуулсан.	100.0
3.	Арга хэмжээ 3.3. Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх	-	Дүгнүүлэх төрийн албан хаагч, тоо	0	4	Албан хаагчийн гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг хагас жилийн байдлаар үнэлж, дүгнүүлсэн. Жилийн эцсийн байдлаар албан хаагчид гүйцэтгэлийн тайлангаа гаргасан. Үнэлэлт дүгнэлт өгөх ажлын хэсэгт хүргүүлсэн.	70.0
4.	Арга хэмжээ 3.4. Хэлтсийн шуурхайг зохион байгуулж үүрэг даалгаврын биелэлтийг хангуулж, тэмдэглэл хөтлөх	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	0	100	Хэлтсийн 11 удаагийн шуурхайг зохион байгуулж ажилласан.	100.0

1	2	3	4	5	6	7	8
5.	Арга хэмжээ 3.5. Хэлтсийн дарга, ажилтнуудын ээлжийн амралтын саналыг боловсруулан ТЗУХ-т хүргэх	-	Хүргүүлэх санал, тоо	0	1	Ээлжийн амралтын саналыг ТЗУХ-т хүргүүлсэн.	100.0
6.	Арга хэмжээ 3.6. Хэлтсийн хэмжээнд дээд газраас ирүүлсэн тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг нэгтгэн гаргах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	0	100	Дээд газраас ирүүлсэн 13 тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг гаргаж ХЭЗХ-т хүргүүлсэн. Дүүргийн Засаг даргын 87 захирамж, Тамгын газрын даргын 5 тушаалын хэрэгжилтийг гаргаж холбогдох хэлтэст хүргүүлсэн.	100.0
7.	Арга хэмжээ 3.7. Хэлтэст ирсэн албан бичгийг бүртгэн, хариутай бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавьж, мэдээлэх	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	0	100	Хэлтсийн хэмжээнд 459 албан бичиг ирснээс 447 албан бичгийн хугацаанд шийдвэрлэсэн. 12 албан бичиг шийдвэрлэх шатанд. Хугацаа хоцроож шийдвэрлэсэн албан бичиг байхгүй.	100.0
8.	Арга хэмжээ 3.8. 2023 оны архивын материалыг цэгцлэн хүлээлгэн өгөх	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	0	100	Хэлтсийн хэмжээнд 15 хадгаламжийн нэгж бүрдүүлэн Архивын хэлтэст хүлээлгэн өгсөн.	100.0
	ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ						
1.	Арга хэмжээ 4.1. Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг дүүргийн цахим хуудсанд байршуулж иргэд, олон нийтэд сурталчилж ажиллах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	0	100	Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг дүүргийн цахим хуудсанд байршуулж иргэд, олон нийтэд сурталчилсан.	100.0

1	2	3	4	5	6	7	8
2.	Арга хэмжээ 4.2. Улс, нийслэл, дүүрэг, орон нутгийн хөгжлийн сан болон бусад эх үүсвэрээр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын талаарх мэдээллийг цахим хуудсанд байршуулж иргэд олон нийтэд мэдээлэх	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	0	100	Дүүргийн www.Shd.mn цахим хуудсанд байршуулж иргэд олон нийтэд мэдээлсэн.	100.0
3.	Арга хэмжээ 4.3. Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2025 онд хийгдэх ажилд иргэдээс санал авах ажлыг зохион байгуулах	10.0 сая	Хамрагдах иргэн, хувь	-	60	Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйл болон Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 5.2-т заасны дагуу 2025 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлын санал асуулгыг 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдрийн хооронд цаасан болон цахим хэлбэрээр зохион байгуулсан. Санал асуулгыг дүнгээр камержуулалт, хатуу хучилттай зам, явган хүний зам гэсэн ажлууд хамгийн их санал авсан. Хороодоос ирүүлсэн саналын хүрээнд хураангуй жагсаалт үүсгэн 2024 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэний дагуу зураг, төсвийг хийлгэж байна.	100.0
4.	Арга хэмжээ 4.4. Төсөл хөтөлбөрөөр хийгдэж байгаа ажлуудын мэдээллийг нэгтгэн, удирдлагуудыг мэдээллээр хангах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	0	100	НҮБ-ийн Хүүхдийн сангийн санхүүжилтээр хэрэгжих "Улаанбаатар хотын үерийн эрсдэлтэй бүсэд нийгмийн эрүүл мэндийг хамгаалж ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн байдлыг сайжруулах нь" төслийн хүрээнд 24 дүгээр хороонд ус түгээх байрыг шинэчлэн барьж, барилгын ажлын	100.0

						явц 90 орчим хувьтай байна. НҮБ-ийн Хүүхдийн сангийн 400.0 сая төгрөгийн санхүүжилтээр хэрэгжих 21 дүгээр хороо, 74 дүгээр сургуулийн хичээлийн болон дотуур байрны ариун цэврийн байгууламжийг бүрэн шинэчлэн засварлаж дууссан. НҮБ-ын Хабитатын Монгол дахь салбараас хэрэгжүүлж буй дүүргийн 4, 5, 26, 27 дугаар хороодын нутаг дэвсгэрт “Гэр хорооллын иргэдийн үерийг тэсвэрлэх чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд хөрсний ус зайлуулах 2,2 км шугам сүлжээний ажил төлөвлөгдсөнөөс 26 дугаар хороонд 700м2 газарт цөөрөм, эргийн хамгаалалтын ажил хийгдэж байгаа бөгөөд 60 хувьтай байна. Дүүргийн Засаг даргын 2024 оны А/632, А/651 дүгээр захирамжуудаар 16 иргэний газар, үл хөдлөх хөрөнгийг дүүргийн төсвийн 1,2 тэрбум төгрөгийн хөрөнгөөр нөхөн олговортой чөлөөлсөн.	

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ХЯНАСАН:

ТГУХ-ийн дарга А.БАТСАЙХАН

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

ТГУХ-ийн ахлах мэргэжилтэн Ө.НОРОВДЭМИД

145

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
8 дугаар хавсралт

ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА А.БАТСАЙХАНЫ 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА А.БАТСАЙХАНЫ 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар

Нэгжийн нэр: Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтэс

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин	Нийт (70 оноо)
1	2	3	4
1.	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	Биелэлтийн хувь 91.1%	63.7

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ
1.	Сургалтад хамрагдах: Сонгуулийн ажилтны сургалтад хамрагдаж сертификат авсан.		12.0
2.	Хэрэглээний программд ажиллах чадвараа сайжруулах: Excel программд ажиллах чадвараа сайжруулсан.		12.0
Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо			12.0

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ

Д/д	Үзүүлэлт	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Хандлага, ёс зүй	10.0
2.	Удирдан зохион байгуулах	12.0
3.	Асуудал шийдвэрлэх	12.0
4.	Манлайлах	10.0
5.	Багаар ажиллах	12.0
6.	Харилцаа	13.0
Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо		12.1

4. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт	63.7
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	12.0
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ	12.1
4.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт	
Нийт оноо		87.8

Үнэлгээ өгсөн:
ЗДТГ-ын дарга

Төсвийн шууд захирагч
..... /Д.Төмөрбаатар/
2024.12.18 (огноо)

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:
ТГУХ-ийн дарга

Нэгжийн дарга:
..... /А.Батсайхан/
2024.12.18 (огноо)

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 00 дугаар тушаалын
7 дугаар хавсралт

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2024 оны 11 дүгээр сарын 25 Улаанбаатар хот

БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ.

д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		
НЭГ. "АЛСЫН ХАРАА-2050" МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД:								
Зорилт 1.3.Монгол хэл, бичгээ үндэсний үнэт зүйлийн бүрдэл болгон иргэн бүр чанартай эзэмшиж, хэрэглэж хэвшинэ.								
1	1.3.1.Төрийн байгууллагын албан хаагч, ажилтнуудад "Монгол бичиг"-ийн анхан шатны мэдлэг олгох сургалтуудыг үе шаттай зохион байгуулах	5,0 ЗДТГ-ын төсөв	Зохион байгуулсан сургалт, тоо	0	1	0	Төрийн байгууллагын албан хаагч, ажилтнуудад "Монгол бичиг"-ийн анхан шатны мэдлэг олгох сургалтыг төрийн 16 байгууллагад үе шаттайгаар зохион байгууллаа. "Монгол бичиг"-ийн анхан шатны мэдлэг олгох сургалтад төрийн байгууллагын 639 албан хаагч хамрагдсан.	100
			Хамруулсан албан хаагч, тоо	0	32	0		
Зорилт 1.4.Үнэт зүйлийн судалгаа болон олон улсын монгол судлалын тэргүүлэх чиглэлүүдийн судалгааг салбар тус бүрээр гүнзгийрүүлэн хийж, нийтийн хүртээл болгох үе.								
2	1.4.1.Орон нутаг судлах кабинет байгуулах ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах	40,0 Дүүргийн төсөв	Байгуулсан кабинет, тоо	0	1	1	Орон нутаг судлах танхим байгуулах судалгааны ажлын хүрээнд 2024 оны 12 дугаар сарын 15-ны өдөр Монголын үндэсний музейтэй хамтран тамгын газрын дотоод хэлтэс тасгийн нийт 15 удирдах албан тушаалтныг сургалтад хамруулаа.	100
Зорилт 2.2.Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлнэ.								
3	2.2.1. Сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд	5,0	Зохион байгуулсан	0	1	-	Эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгах цахим нөлөөллийн арга	100

	нөлөөлөх хүчин зүйлийг багасгах цахим нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах	Дүүргийн төсөв	арга хэмжээ, тоо				хэмжээг дүүргийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/954 дүгээр захирамжаар 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 02 дугаар сарын 28-ны өдрийн хугацаанд зохион байгууллаа. Арга хэмжээний хүрээнд "Цахим ведио контент хийх аргачлал"-ын сургалтыг 4 удаа зохион байгуулж 120 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулан чадавхжуулж, гал түймэрээс сэргийлэх рийл-9, шторк-20, подкаст-4, цахим хичээл-32, нийт-65, зам тээврийн осол гэмтэл, бэртэлээс сэргийлэх рийл-6, шторк-12, цахим хичээл-14 нийт-32, бүгд 87 видео бэлтгэн олон нийтийн сүлжээ, байгууллага аж ахуй нэгжийн цахим групп зэрэг 75 цахим сувгаар цацаж 29,592 үзэлт, 10,087 хандалт авсан ба 106 сургууль, цэцэрлэг, ААНБ-тай хамтран ажиллалаа.	
Зорилт 2.3.Хүн амын тогтвортой өсөлтийг дэмжиж идэвхтэй, бүтээлч иргэн, гэр бүлийг төлөвшүүлнэ.								
4	2.3.1.Хүүхдийн хөгжил, авьяас, ур чадварыг нэмэгдүүлэх эцэг, эх, асран хамгаалагчдийн оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, эцэг эхийн зөвлөлтэй хамтран ажиллах.	10,0 Дүүргийн төсөв	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	0	2	-	Дүүргийн хэмжээнд Засаг даргын Тамгын газарын эцэг эхийн зөвлөлтэй хамтран дүүргийн төрийн албан хаагчдын гэр бүлийн гишүүдийн дунд "Олон улсын гэр бүлийн өдөр"-ийг тохиолдуулан "HAPPY FAMILY" арга хэмжээг "Найрамдал цогцолбор"-т зохион байгуулсан. Тус арга хэмжээний хүрээнд гэр бүлийн гишүүдийн дунд халуун дулаан уур амьсгалыг бүрдүүлж, бие биенээ хайрлах, гэр бүлийн үнэ цэнийг эрхэмлэх, хосын харилцаан дахь эерэг хандлагыг нэмэгдүүлэх зорилгоор дараах хөтөлбөрүүдийг хэрэгжүүллээ. Үүнд: "Урлагийн сэтгэл заслын хөтөлбөр" буюу уран зургийн хэрэглэгдэхүүн ашиглан хосоороо байгалд зураг зурж, зурсан зурагаа бие биедээ бэлэглэх хосын болзоо, "Аав, ээж бид 3" хөгжөөнт буухиа тэмцээн, Аавуудын дунд өрсөлдөөнт танин мэдэхүйн асуулт хариултын	100
			Хамтран ажилласан эцэг, эхийн зөвлөл	5	15	-		

							тэмцээн зохион байгуулж, Хүүхэд багачуудын дунд "Би аав, ээждээ хайртай" буланг ажлуулж, танин мэдэхүйн асуулт хариулт болон бүжгийн тэмцээнийг тус тус зохион байгуулж, нийт 200 гаруй гэр бүл оролцсон. Дүүргийн хүүхдийн зөвлөл, хөвгүүдийн зөвлөл, охидын зөвлөл, өсвөрийн сэтгүүлч бүлгэм, өсвөрийн улаан загалмайн хороо, өсвөрийн сэргийлэгч бүлгэм, өсвөрийн парламент-2024 хөтөлбөрийн үйл ажиллагаанд чиглэл, арга зүй өгч ажиллах, үйл ажиллагааг дэмжиж ажилласан. Үүнд хүүхдийн өөрөө удирдах 6 байгууллагын 11 үйл ажиллагааг дэмжин, 1,366 хүүхдийг хамруулж, хүүхдийн өөрөө удирдах байгууллагуудын гишүүдийг чадавхжуулах 3 удаагийн сургалт, арга хэмжээ зохион байгуулж 83 гишүүнийг хамруулсан. Хүүхдийн өөрөө удирдах 6 байгууллагын 11 үйл ажиллагааг дэмжин, 1,366 хүүхдийг хамруулж, хүүхдийн өөрөө удирдах байгууллагуудын гишүүдийг чадавхжуулах 3 удаагийн сургалт, арга хэмжээ зохион байгуулж 83 гишүүнийг хамруулсан.	
Зорилт 3.3.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, бизнес эрхлэх арга, ур чадварыг хөгжүүлж, жижиг, дунд бизнес эрхлэлтийн өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.								
5	3.3.1.Оёдлын бизнес эрхлэгчдийн чуулган, уралдаан, тэмцээн зохион байгуулах	20,0 Дүүргийн төсөв	Зохион байгуулах арга хэмжээ, тоо	0	1		Дүүргийн бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих, салбар дундын уялдаа холбоог бэхжүүлэх, инноваци шингэсэн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг хөгжүүлэх, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдөр зөвлөгөөн зохион байгуулж, нийт 760 үйлдвэрлэл эрхлэгчдийг хамруулаа. Тус зөвлөгөөнөөр нөлөөллийн ажил, хэлэлцүүлэг,	100

							үзэсгэлэн худалдаа гэсэн үндсэн үйл ажиллагаа зохион байгуулагдсан бөгөөд ижил төстэй үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүнээс ялгарах онцлог, брэнд бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах, үр ашиг, ажлын байрыг нэмэгдүүлэн бүтээгдэхүүнээ дэлхийн зах зээлд гаргах боломжийн талаарх мэдээллийг хүргэж ажиллалаа. Хүний нөөц, ур чадвар зэрэг олон тулгамдаж буй асуудлыг оёдолчдын ур чадварын төвшинтэй хамт тодорхойлж, зөвлөмж гарган хэлэлцүүлэг зохион байгуулснаар дараах үр дүнгүүд гарч байна. Бараа бүтээгдэхүүн борлуулдаг иргэд, худалдан авалт хийдэг иргэдийн хоорондын эрэлт нийлүүлэлтийн уялдаа холбоог сайжруулсан, оёмол бүтээгдэхүүний эрэлт ихтэй төрийн болон томоохон аж ахуйн нэгж байгууллагыг оёдлын үйлдвэрлэл эрхлэгчтэй холбож, дүүргийн томоохон худалдан авалтад оруулах боломжтой бүтээгдэхүүний нөөцийг тодорхойлсон.	
ХОЁР. НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХАМААРАЛТАЙ ЗААЛТУУДЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД:								
6	1.1.1.Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх, шинээр оношлогдсон өвчлөлийн хяналтын чанарыг сайжруулах	10,0 Дүүргийн төсөв	Эрт илрүүлэгт хамрагдсан иргэн, тоо	15.100	2500	2500	Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгт 2024 оны байдлаар 269.796 хүн амаас 157,921 иргэнийг хамруулсан. 18.196 өвчлөлийг илрүүлж, хяналтанд авч эрүүлжүүлэн, 171 хавдрын өвчлөлийг хяналтад авч, эмчилгээнд хамруулж байна. Эрт илрүүлэг, үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 113 байгууллага, аж ахуйн нэгжид 2024 оны 03/166 дугаар албан бичгээр чиглэл хүргүүлснээр 215 байгууллагын 13778 албан хаагч үзлэгт хамрагдаж 6017 өвчлөл, үүнээс 1 хавдрын	100
			Хяналтад орсон өвчлөл, тоо	971	150	150		
			Эрүүлжилтийн хувь	45	70	70		

							өвчлөл илрүүлэн дараагийн шатлалд шилжүүлэн, 100% эрүүлжүүлсэн.	
7	1.1.2.Эрэгтэйчүүдийн кабинетийг шинээр байгуулах зохион байгуулалтын арга хэмжээ авах	-	Байгуулсан кабинет, тоо	-	1	-	Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих, үзлэг, оношлогоог нэмэгдүүлэх зорилгоор Нэгдсэн эмнэлгийн 1 дүгээр амбулаторид эрэгтэйчүүдийн уралогийн кабинетийг байгуулж, 1 эмчийг мэргэшүүлж, 2024 оны байдлаар 433 эрэгтэйд үзлэг, оношлогоо хийсэн.	100
8	1.1.3.Багийн спортыг дэмжих чиглэлээр өсвөрийн хүүхэд, багачуудыг уралдаан, тэмцээнд оролцуулах зохион байгуулалтын арга хэмжээ хэрэгжүүлэх.	10,0 Дүүргийн төсөв	Оролцсон уралдаан, тэмцээний тоо	1	2	0	"Улаанбаатар лиг-2024" сагсан бөмбөгийн тэмцээнийг 2 үе шаттай зохион байгуулж бүсийн аварга шалгаруулах тэмцээнд 54 байгууллагын 2400 тамирчдыг хамруулсан ба Нийслэлийн Засаг даргын нэрэмжит "Улаанбаатар лиг" сагсан бөмбөгийн XIV дэх удаагийн шигшээ тэмцээнд дүүргээс шалгарсан 12 багийн 144 сурагч өрсөлдсөнөөс бага насны эмэгтэй ангилалд 151-р сургуулийн охидын баг, 62-р сургуулийн хөвгүүдийн баг 1-р байр тус тус эзэлж алтан медаль хүртсэн. Мөн шилдэг дасгалжуулагч багшаар 62-р сургуулийн Р.Нэргүйбаатар, 151-р сургуулийн Б.Оюунтунгалаг, шилдэг тоглогчоор 62 дугаар сургуулийн хөвгүүдийн багийн тамирчин, охидын багийн шилдэг тоглогчоор 151-р сургуулийн Х.Хулан нар шалгарсан."Улаанбаатар лиг" волейболын тэмцээнийг 2024 оны 03 дугаар сарын 9-10-ны өдрүүдэд дунд, ахлах насны ангилалаар зохион байгуулж, ерөнхий боловсролын 26 сургуулийн 600 гаруй сурагчид оролцож, хурд хүч авхаалж самбаа, ур чадвараараа өрсөлдсөн.	100
9	1.1.4.Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийн нэгдсэн судалгаа гаргах.	-	Судалгаа тоо	-	1	-	Дүүргийн Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгч иргэдийн нэгдсэн судалгааг 12 ангилалын дагуу Жижиг дунд үйлдвэрийг дэмжих	100

							мэдээлэл сургалтын төв, 43 хороотой хамтран гаргасан. Үүнд:Хувцас загвар-144, Дүрслэх урлаг-105, Дуу хөгжим-10, Соёлын өв-1, Нийт 260 иргэн, ААНБ байна. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор Соёлын яам, НЗДТГ, НСУГ-аас зохион байгуулсан "Бүтээлч хот" болзолт уралдаанд амжилттай оролцож ААНБ төрөлд тэргүүн байр, "Дүүрэг" төрөлд дэд байр, Хороо төрөлд гутгаар байранд шалгарсан.	
10	1.1.5.Индексийн урамшуулалд шалгарсан ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн туршлагыг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах.	-	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	2	2	-	2024 оны тэргүүний сургууль, цэцэрлэг шалгаруулах гүйцэтгэлийн үнэлгээний шалгалт ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад хийгдэж, гүйцэтгэлийн үнэлгээнд 1-4 дүгээр түвшинд үнэлэгдсэн 7 сургууль, 18 цэцэрлэг туршлагаа түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг зохион байгуулж, 79 сургалтад 5954 багш хамрагдсан.	100
ГУРАВ. ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХҮРЭЭНД:								
3.1. Иргэд олон нийтийг "Ковид-19" цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж, нөөцийн бэлэн байдлыг хангана.								
11	1.1.1. Үүссэн нөхцөл байдалтай уялдуулан тухай бүр цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилтийг хангах, эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах	Засаг даргын нөөц	Үйл ажиллагаан ы хэрэгжилт, хувиар	100	50	50	Коронавируст халдвар (Ковид 19) өвчний тохиолдол бүртгэгдээгүй байна.	0
12	1.1.2.Улирлын чанартай томуу, томуу төст өвчин, амьсгалын замын халдварт өвчин, цар тахлаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг байгууллага,	-	Зохион байгуулсан сургалт, тоо	10	5	5	Эрүүл мэндийн болон Өрхийн Эрүүл мэндийн төвийн нийгмийн ажилтан нар эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлж буй нийт 124,780 хүн амд "Амьсгалын замын халдвараас сэргийлэх", "Гарын ариун цэвэр сахих арга", "Амны хаалтыг зөв хэрэглэх" "Дархлаагаа хэрхэн дэмжих вэ" зэрэг сэдвүүдээр ажлын	100
			Хамрагдсан байгууллага, тоо	20	10	10		

	аж ахуйн нэгжүүдэд зохион байгуулах.						байранд 11 удаагийн сургалт, цахим хуудсанд 11 төрлийн постер, 1 төрлийн сурталчилгааны материал, 1 видео хичээлийг байршуулж 87.410 иргэнд мэдээлэл хүргэсэн. Дүүргийн нийт 25 хүүхдийн байгууллагад урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулж 5700 хүүхэд, 44 багш ажилчдыг хамруулж, 452 эцэг эхэд халдвараас хэрхэн сэргийлэх талаар 2 удаагийн сургалтыг зохион байгуулж, 2450 ширхэг тарааах материал тараасан байна. Томуу, томуу төст өвчний шинж тэмдэг, шинэ эмчилгээний 2 удаагийн сургалтад 31 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг, 28 удаагийн сургалтаар 2616 иргэн, 65 байгууллагын 99 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд томуугийн зөвлөгөө мэдээллийг хүргээд байна. 2024 оны байдлаар томуугийн дархлаажуулалтад хүүхэд 16,723, ахмад7234, жирэмсэн буюу ХБИ 8265, нийт 32,222 хүн амыг хамруулсан байна.	
Зорилт 3.2. Дүүргийн хүн амын эрүүл мэндийг халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж, эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн ур чадварыг дээшлүүлнэ.3.2.								
13	2.1.1.Эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах, төсгсөлтийн дараах болон мэргэшүүлэх сургалтад хамруулах, дэмжлэг үзүүлэх, нийгмийн баталгааг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	-	Сургалтад хамрагдсан албан хаагч, тоо	300	150	150	2024 оны жилийн эцсийн байдлаар эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах, төгсөлтийн дараах болон мэргэшүүлэх сургалтад хамруулах ажлыг зохион байгуулж мэргэжил дээшлүүлэх сургалтад 20 эмч, 10 сувилагч, 22 мэргэжилтэн, дадлагажуулах сургалтад 55 эмч, 22 сувилагч, бусад мэргэжлийн сургалтад 494 эмч, 168 сувилагч, 45 мэргэжилтэн, нийт 836 хүнийг хамруулаад байна. Нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд 39 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд түрээслээд, өмчлөх эрхтэй орон сууцны батламжийг гардуулж, үндсэн цалинг 10%-иар	100

							нэмэгдүүлэн, 20 эмч, 18 сувилагчиийг 19 сая төгрөгөөр шагнаж, урамшуулсан.	
14	2.1.2.Дотоод, гадаадын улс орны сайн туршлагаас судлах үйл ажиллагаанд эмч мэргэжилтнүүдийг хамруулах	-	Хамрагдах мэргэжилтэн, тоо	200	100	100	Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагааг сайжруулах, ижил төстэй байгууллагаас суралцах "Туршлага түгээн дэлгэрүүлэх" арга хэмжээг 3 удаа зохион байгуулж 141 эмч, эмнэлгийн мэргэжилт-нүүдийг хамруулаа. Бүгд Найрамдах Турк улс, Солонгос улсын Мёнжи эмнэлгийн байгууллагын үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах үйл ажиллагаанд нийт 33 эмчийг хамруулаад байна. 2024 онд БНХАУ-ын ӨМӨЗО-нд 2 сувилагчийг 5 хоногийн, 1 эмчийг Австри улсын Граз эмнэлэгт 28 хоногийн, 1 эмчийг Японы хөхний төвд 5 хоногийн, 3 эмчийг үе солих, хавдрын мэс засал, эмнэлзүйн чиглэлээр 24 хоногийн, 1 эмчийг БНХАУ-д зүү эмчилгээний 5 хоногийн, 1 эмчийг Тайвань улсад уламжлалт эмчилгээний чиглэлээр тус тус сурган, төгсгөөд байна. Мөн Турк, Сингапор улсуудад зохион байгуулагдсан эрдэм шинжилгээ, судалгааны олон улсын хуралд 2 эмч оролцлоо. Нийслэл, дүүргийн "Сайн туршлага" арга хэмжээнд дүүргийн 91 эмч, эмнэлгийн мэргэжилтэн оролцож 3 бүтээлээр "Тэргүүн байр" эзэлж, гэрчилгээ гардан авч, сайн туршлагын номонд тэмдэглэгдлээ.	100
15	2.1.3."Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх" төслийн 2024 оны төлөвлөгөөг боловсруулж, батлуулан, хэрэгжилтийг хангах	50,0 Дүүргийн төсөв	Боловсруул-сан төлөвлөгөө, тоо	1	1	-	"Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх" төслийн 2024 оны төлөвлөгөөг 17 арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлуулан, хэрэгжилтийг 96.2%-тай ханган ажиллалаа. Төслийн хүрээнд цахимаар 341, танхимаар 167 удаагийн сургалтыг зохион байгуулж 43,971 иргэнд мэдээлэл олгоод, байна. Товлолт дархлаажуулалтад 18,608 хүүхэд	100
			Төлөвлөгөө-ний хэрэгжилт, хувь	0	60	40		

							хамруулахаас 18,199 хүүхдийг хамруулж 97,8%-тай байна. Сүрьеэ өвчнийг эрт илрүүлэх, эрүүлжүүлэх ажлын хүрээнд 63 удаагийн үзлэгээр 4200 иргэнийг хамруулж 51 өвчлөлийг, БЗДХ-ын үзлэг 70 удаа зохион байгуулж 47 байгууллагын 7767 албан хаагчийг хамруулж 352 өвчлөлийг, вируст хипатит буюу элэгний В, С илрүүлэх үзлэгийг 64 удаа явуулж 8735 иргэнийг хамруулж 426 өвчлөлийг тус тус илрүүлж, 373 иргэнийг эрүүлжүүлээд байна. Өсвөр үеийнхнийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 43 үе тэнгийн сургагч багшийг бэлтгэж, чадавхжуулан 1944 хүүхдэд мэдээлэл олгоод байна. 2024 онд жирэмсэн эмэгтэйн тэмбүүгийн шинэ тохиолдол 26, хуучин-155 тохиолдол бүртгэгдэн, 100% эрүүлжүүлсэн ба төрөлхийн тэмбүүгийн тохиолдол бүртгэгдээгүй байна.	
1.	Нийслэл, дүүргээс зохион байгуулж буй төрийн албан хаагчдыг чадваржуулж, мэргэшүүлэх сургалтад тухай бүрд хамрагдах	Хамрагдсан сургалтын тоо	2	4	Удирдлагын Академи төрийн албаны сургуулийн төрийн албан хаагчийн дунд хугацааны давтан сургалтад хамрагдсан. Монгол бичгийн сургалтад хамрагдсан. Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдал /DET/ үйлчилгээний сургалтад хамрагдан батламж авсан.	01.02-12.20	100
2	Хууль эрх зүйн чиглэлээр суралцах	Хамрагдсан сургалтын тоо	0	1	Их Засаг Их сургуульд "Эрх зүйч" мэргэжлээр бакалаврын ангид суралцаж байна.	01.02-12.20	100

ТАЙЛАН ГАРГАСАН:
НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
(Албан тушаал)

А.ДАВААСҮРЭН / ..... /
(Нэр, гарын үсэг)

2018 12 18
(Огноо)

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН АЛТАНСҮХИЙН ДАВААСҮРЭНГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН АЛТАНСУХИЙН ДАВААСҮРЭНГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС
(ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛТАН)

Байгууллагын нэр: Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар
Нэгжийн нэр: Нийгмийн хөгжлийн хэлтэс

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаа жуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 1. "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, 40-өөс дээш насны 1000 иргэний ажлын байрыг нэмэгдүүлэн, иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлнэ" зорилтийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
1.	Арга хэмжээ 1.1.40-өөс дээш насны иргэдэд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд ажлын байрыг бий болгож, ажил хайгч болон ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэдийг байнгын болон түр ажлын байранд зуучлах үйлчилгээг үзүүлэх	60	10	70	
2.	Арга хэмжээ 1.2."Эрэгтэйчүүдийн хөгжлийн төв", "Эмэгтэйчүүдийн хөгжлийн төв"- үүдийн үйл ажиллагааг дэмжиж байнгын ажлын байрыг тогтмолжуулах	60	10	70	
3.	Арга хэмжээ 1.3."Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих төсөл"-ийн 2024 оны төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажиллах	54	10	64	
Зорилт 2. "Мэргэжлийн ур чадвар олгох сургалтад 500 иргэн, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг бизнесээ хөгжүүлэх сургалтанд 2500-аас доошгүй иргэдийг хамруулан чадавхжуулж, хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг үзүүлнэ" зорилтийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
4.	Арга хэмжээ 2.1. Мэргэжлийн ур чадвар олгох сургалтад хамрагдах хүсэлтэй, ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийн судалгааг гарган, сургалтад хамруулж хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх	48	10	58	
5.	Арга хэмжээ 2.2. Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид болон хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд, аж ахуйн нэгж байгууллагын ажиллагсдад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэдлэг олгох, мэдээллээр хангах	60	10	70	

	ажлын хүрээнд аяныг зохион байгуулах.				
6.	Арга хэмжээ 2.3. Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийг бизнесээ хөгжүүлэх сургалтад хамруулан чадавхжуулж, хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх	60	10	70	
Зорилт 3. "Нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлж халамжаас хөдөлмөрт бодлогыг хэрэгжүүлнэ" зорилтийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
7.	Арга хэмжээ 3.1. Халамжаас хөдөлмөрт бодлогын хүрээнд зорилтот өрхийг ОУБ-ын болон орон нутагт хэрэгжих төсөл хөтөлбөрт хамруулж, иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах өдөрлөг, туршлага солилцох уулзалт зохион байгуулах	60	10	70	
8.	Арга хэмжээ 3.2. Зорилтот бүлгийн болон хүнс тэжээлийн дэмжлэг тусламжийн үйлчилгээнд хамрагдсан эмзэг эрсдэлтэй бүлгийн иргэдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээг үзүүлэх	60	10	70	
9.	Арга хэмжээ 3.3. Зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих "Эмэгтэйчүүдийн хөгжлийн төв", "Гар урлал-Инновацийн төв", "Эрэгтэйчүүдийн хөгжлийн төв"-ийн үйл ажиллагааг өргөжүүлж, ажлын байраар хангах	48	10	58	
10.	Арга хэмжээ 3.4. Зорилтот бүлгийн өрх, иргэний ухамсар зан төлөвийг өөрчилж, нийгэмшүүлэн, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болоход чиглүүлэх төсөл, хөтөлбөрт хамруулах	60	10	70	
11.	Арга хэмжээ 3.5. Зорилтот бүлгийн ажил, мэргэжилгүй иргэдэд мэргэжил олгох аян зохион байгуулах	60	10	70	
Зорилт 4. "Хүүхэд залуучууд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмадын талаарх төрөөс баримтлах бодлогыг дүүргийн түвшинд хэрэгжүүлэх, ахмад настан, өрх толгойлсон эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжиж ажиллана" зорилтийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
12.	Арга хэмжээ 4.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах, хөгжүүлэх чиглэлээр иргэн болон төрийн бус байгууллагуудын санаачилгыг дэмжиж ажиллах	60	10	70	
13.	Арга хэмжээ 4.2. Зорилтот бүлгийн ахмад настан, өрх толгойлсон эцэг, эхийг олон нийтийн оролцоонд	60	10	70	

	түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамруулах				
14.	Арга хэмжээ 4.3. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих “Старт ап” хөтөлбөрийг хэрэгжүүлэх	54	10	64	
Зорилт 5. “Ахмадад эелтэй дүүрэг” төслийг хэрэгжүүлнэ” зорилтийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
15.	Арга хэмжээ 5.1. Ахмадад эелтэй дүүрэг” төслийг батлуулж хэрэгжүүлэх	54	10	64	
16.	Арга хэмжээ 5.2. Ахмадын өргөө, хөгжлийн төвийг байгуулж үйл ажиллагааг нь дэмжиж өргөжүүлэх	54	10	64	
17.	Арга хэмжээ 2.2.1 Сайн дурын нийгмийн даатгалд даатгуулахын ач холбогдлыг таниулах цахим сургалт, сурталчилгааг зохион байгуулах, хамрагдалтыг нэмэгдүүлэх	60	10	70	
Дундаж оноо:				**67**	

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1.	Арга хэмжээ 1. Нийслэл, дүүргээс зохион байгуулж буй төрийн албан хаагчдыг чадваржуулж; мэргэшүүлэх сургалтад тухай бүрд хамрагдах	15	15	
2.	Арга хэмжээ 2. Хууль эрх зүйн чиглэлээр суралцах	15	15	
Дундаж оноо			**15**	

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	7	
2.	Дүн шинжилгээ хийх	7	
3.	Асуудал шийдвэрлэх	7	
4.	Хариуцлагатай байдал	7	
5.	Ажлын цаг ашиглалт	7	
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
6.	Мэргэжлийн ур чадвар 1.	7	
7.	Мэргэжлийн ур чадвар 2.	7	
8.	Мэргэжлийн ур чадвар 3.	7	
Дундаж оноо		**7**	

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (0-8 оноо)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	8
2.	Багаар ажиллах	8
3.	Харилцаа	8
	Дундаж оноо	**8**

5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)*	67
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	15
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Нэгжийн даргын үнэлгээ)*	7
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)*	8
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)*	*(97 оноо)*
	Нийт оноо = 97 (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)*) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо	97 оноо

Үнэлгээ өгсөн: ***Нэгжийн дарга***

НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

/.....Т.БАЯРМАА/

(албан тушаал) *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2024.12.15 *(огноо)*

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн: ***Төрийн жинхэнэ албан хаагч:***

НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГУУЛЛЫН
АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

(албан тушаал) /.....А.ДАВААСҮРЭН/

(гарын үсэг) *(албан хаагчийн нэр)*

2024.12.18 *(огноо)*

Үнэлгээг хянасан:

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА
(албан тушаал) /.....Тууя.....*(гарын үсэг)* (С.ТУУЛМАА)
(албан хаагчийн нэр)

2024.12.16 *(огноо)*

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ЗАХИРГААНЫ БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
(албан тушаал) /.....*(гарын үсэг)* (Ц.САРАНЦЭЦЭГ)
(албан хаагчийн нэр)

2024.12.16*(огноо)*

Үнэлгээг баталгаажуулсан: ***Төсвийн шууд захирагч***

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА
(албан тушаал) /.....*(гарын үсэг)* (Д.ТӨМӨРБААТАР)
(албан хаагчийн нэр)

2024.12.18 *(огноо)*

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Г.АНХЖАРГАЛЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД, ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА ХАРИУЦСАН МЭРЭЖИЛТЭН ГАНЦОЛМОНГИЙН АНХЖАРГАЛЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		
	1	2	3	4	5	6	7
Хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийг бууруулах талаар холбогдох шийдвэрүүдийг гарган, хүчирхийлэлд өртөгчдийг хамгаалах байртай болж, гэр бүлийн гишүүдийн хариуцлагыг нэмэгдүүлэн, үлгэр жишээ гэр бүлийг дэмжин, сурталчлах, хүүхдийн эрхийг дээдэлж, залуучуудыг хөгжих, суралцах, хөдөлмөрлөх орчин нөхцөлөөр хангана.							
Зорилт 1. "Төрөөс хүүхэд, залуучуудын талаар баримталж буй хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, хянах, тайлагнах" зорилтыг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт							
1.	Арга хэмжээ 1.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, тэдний эцэг эх, асран хамгаалагчдын нийгмийн оролцоог нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах	Зохион байгуулах арга хэмжээний тоо	3	1	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон тэдний эцэг эх, асран хамгаалагчдын тэгш оролцоог дэмжих, хүүхдийн эрх, хамгаалллын талаар мэдлэг олгох, спорт, биеийн тамираар дамжуулан хөгжүүлэх, идэвхжүүлэх зорилготой спортын 3 төрөлт арга хэмжээг Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгаалллын хэлтэс, Биеийн тамир спортын хороо, дүүргийн 43 хороо, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалллын салбар комисс, "Хүүхэд, гэр бүлийн тэгш хөгжил" ТББ, "Эвт гурван тулгуур" ТББ зэрэг байгууллагуудтай хамтран зохион байгуулсан бөгөөд тус арга хэмжээнд нийт хөгжлийн бэрхшээлтэй 150 гаруй хүүхэд, 150 гаруй эцэг эх, асран хамгаалагчид оролцсон. Мөн "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл	01.31-12.09	100%

					мэндийг дэмжих" арга хэмжээг 2 өдрийн турш Сонгинохайрхан Нэгдсэн эмнэлэг дээр үнэ төлбөргүй зохион байгуулж нийт 600 гаруй тусгай хэрэгцээт хүүхдүүдийг нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамруулж, эцэг эх, асран хамгаалагчдад Сэтгэлзүйн болон Хууль эрх зүй, хоол зүй, хөдөлгөөн, хэл заслын зөвлөгөө мэдээллийг хүргэж, ажилласан бөгөөд Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэс, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв, Дэлхийн Зөн Монгол /World Vision Mongolia, Тэгш хамруулах боловсролыг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлдэг 9, 65 дугаар сургууль зэрэг байгууллагуудтай хамтран ажиллалаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчдын оролцоог дэмжих, хөгжүүлэх, нийгмийн харилцаанд тэгш оролцуулах, мэдлэг мэдээллээр хангах зорилгоор "Мэдлэг нэмье" өртөөчилсөн арга хэмжээг зохион байгууллж нийт 130 гаруй эцэг эх, асран хамгаалагчид оролцсон.		
2.	Арга хэмжээ 1.2. Залуу гэр бүлүүдэд зориулсан сургалт, нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулж хэвшүүлэх	Зохион байгуулах сургалтын тоо	8	4	Дүүргийн "Гэрлэх ёслолын өргөө"-ний үйл ажиллагааг өргөжүүлэх, олон нийтэд суртачлан таниулах арга хэмжээний хүрээнд дүүргийн Засаг даргын 2024 оны А/29 дүгээр захирамж гарсан. Тус захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хэсгийн хурлыг зохион байгуулж 2024 оны төлөвлөгөөг баталж ажилласан. Мөн "Эрүүл, жаргалтай гэр бүл" нөлөөллийн үйл ажиллагааг цуврал байдлаар 7 удаа зохион байгуулж нийт 43 байна.	01.31-12.09	100%

		Сургалтад хамрагдах иргэдийн тоо	200	120	Мөн жилийн эцсийн байдлаар нийт 54 хосын хуримын ёслолын арга хэмжээг зохион байгуулж ажилласан. Дүүргийн хэмжээнд Засаг даргын Тамгын газар, Эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагууд болон ерөнхий боловсролын сургууль, хорооны төрийн албан хаагчдын гэр бүлийн гишүүдийн дунд "Олон улсын гэр бүлийн өдөр"-ийг тохиолдуулан "HAPPY FAMILY" арга хэмжээг "Найрамдал цогцолбор"-т зохион байгуулсан. Тус арга хэмжээний хүрээнд гэр бүлийн гишүүдийн дунд халуун дулаан уур амьсгалыг бүрдүүлж, бие биенээ хайрлах, гэр бүлийн үнэ цэнийг эрхэмлэх, хосын харилцаан дахь эерэг хандлагыг нэмэгдүүлэх зорилгоор дараах хөтөлбөрүүдийг хэрэгжүүллээ. Үүнд: "Урлагийн сэтгэл заслын хөтөлбөр" буюу уран зургийн хэрэглэгдэхүүн ашиглан хосоороо байгалд зураг зурж, зурсан зурагаа бие биедээ бэлэглэх хосын болзоо, "Аав, ээж бид 3" хөгжөөнт буухиа тэмцээн, Аавуудын дунд өрсөлдөөнт танин мэдэхүйн асуулт хариултын тэмцээн зохион байгуулж, Хүүхэд багачуудын дунд "Би аав, ээждээ хайртай" буланг ажлуулж, танин мэдэхүйн асуулт хариулт болон бүжгийн тэмцээнийг тус тус зохион байгуулж, нийт 200 гаруй гэр бүл оролцсон.	01.31-12.09	100%
Зорилт 2. "Гэр бүлийн хөгжлийг дэмжих, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажлын хэрэгжилтийг хангуулах, судлах, хяналт тавих, тайлагнах" зорилтыг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт							
	Арга хэмжээ 2.1. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүдийг хамгаалах байрны үйл ажиллагаанд арга зүйн	Зохион байгуулах сургалтын тоо	0	-	Түр хамгаалах байранд тайлант хугацаанд 2023 оноос үргэлжлүүлэн 8 хүүхэд, шинээр 318, нийт 326 хүүхэд хүлээн авч амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор тодорхой хугацаагаар байрлуулан хүүхдийн эрх, хэрэгцээнд нийцсэн цогц хүүхэд	01.31-12.09	74.2%

	дэмжлэг үзүүлэх, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг шуурхай хүргэх				хамгааллын хариу үйлчилгээг үзүүлж, эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлж ажилласан. Нийт насанд хүрсэн 3 иргэн, 326 хүүхдэд давхардсан тоогоор 4149 ор хоногийн хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлж ажилласан.		
3.	Арга хэмжээ 2.2. Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдийг илрүүлэх, хүүхэд үрчлэлт болон асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоолгосон хүүхдүүдийн нөхцөл байдалд эргэн хяналт тавьж ажиллах	Хамрагдах хүүхэд, тоо	220	220	Жилийн эцсийн байдлаар нийт хүүхэд үрчлэлтийн 121, асран хамгаалагч тогтоох 49, харгалзан дэмжигч тогтоох 29, асрамжинд асруулах 6, ар гэрт нь эргэн нэгтгэсэн 3 буюу нийт 208 хүүхдийн материалыг хянаж дүүргийн Засаг даргын захирамжийн шийдвэр гаргах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу 20 хоногийн хугацаанд шийдвэрлэн ажиллаж байна. Мөн эрсдэлт нөхцөл дэх хүүхдийг гэрээр эргэх "Хяналт" арга хэмжээг дүүргийн 43 хорооны хамтарсан багийн 154 албан хаагч, 393 хэсгийн ахлагч, анги удирдсан багш 1,839 нийт 2,386 албан хаагч 1,897 хүүхдийн нөхцөл байдлыг тодруулан ажиллаж, хүүхдийн гэрээр айлчлах хугацаанд 93 зөрчлийг илрүүлэн холбогдох байгууллагад холбон зуучилж ажилласан.	01.31-12.09	100%
		Хяналт тавих ажлын тоо	3	1			
4.	Арга хэмжээ 2.3. Байгууллагын дэргэдэх эцэг, эхийн зөвлөлийг арга зүйгээр хангаж, хүүхэд хүмүүжлийн эерэг аргыг түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах.	Зохион байгуулах арга хэмжээний тоо	8	1	Эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлж, оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр дүүргийн 270, 273, 303 дугаар цэцэрлэгүүдийн багш, ажилчидад "Боловсролын байгууллага дахь хүүхэд хамгаалал", "Хүүхэд хүмүүжлийн эерэг арга", "Гэр бүлийн харилцаа хандлага, үнэ цэн" сургалтуудыг "Галт шувуу" ТББ-тай хамтран зохион байгуулж, эцэг, эхийн зөвлөлийн 50 гишүүн, нийт 250 гаруй иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллалаа. Мөн дүүргийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх 15 нэгжийн 8 хэлтэс, 5 тасаг, 2 албаны 125 албан хаагч, харьяа 28 хэлтсийн	01.31-12.09	100%

					800 гаруй албан хаагчдын дунд байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөл байгуулж ажиллах зөвлөмж, арга зүй өгөх сургалтыг зохион байгуулаад байна.		
5.	Арга хэмжээ 2.4. "Хүүхэд харах" үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд хяналт тавих, дэмжлэг үзүүлэх, зөвшөөрөл олгох, чадавхжуулах ажлыг зохион байгуулах.	Хяналт тавих ажлын тоо	3	-	Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль, "Хүүхэд харах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага-MNS 6540:2015" стандартын дагуу үйлчилгээний хэрэгжилтийн байдалд хяналт тавих, арга зүй өгөх, зөрчил илэрсэн төвүүдэд зөвлөмж, шаардлага хүргүүлэх ажлыг Хүүхэд гэр, бүлийн хөгжил хамгааллын хэлтэс, холбогдох хороодын Засаг дарга нартай хамтран "Хяналт" арга хэмжээг зохион байгуулж ажиллалаа.	01.31-12.09	74.2%
		Чадавхжуулах үйл ажиллагааны тоо	2	-	1 дүгээр улирлын байдлаар дүүргийн хэмжээнд нийт 13 "Хүүхэд харах төв"-д 171 хүүхэд хамрагдаж, 37 багш ажиллаж байна. Тус багш ажилчдын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, чадавхжуулах ажлыг Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын хэлтэстэй хамтран зохион байгууллаа.		
Зорилт 3. "Гэр бүл хүүхэд залуучуудын байгууллага болон хороодын нийгмийн ажилтнуудыг мэргэшил, арга зүйгээр хангах үйл ажиллагааны хэрэгжилтийг хангуулах, хянах, дүгнэх, тайлагнах" зорилтыг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт							
6.	Арга хэмжээ 3.1. Хороодын нийгмийн ажилтнуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах, тайлан мэдээг хянах, дүгнэх ажлыг зохион байгуулах	Тайлан мэдээг хянах, дүгнэх тоо	35	43	Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яам, ЗГХА Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, НЗДХА Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар болон төрийн бус байгууллагуудтай хамтарсан 12 удаагийн чадавхжуулах сургалт, арга зүй өгөх нэгдсэн арга хэмжээний хүрээнд 43 хорооны нийгмийн ажилтнууд хамрагдсан. Мөн "Нийгмийн хамгааллын алхмууд, кейс менежментийн арга зүй", "Хүүхэд хамгааллын шуурхай тусламж, үйлчилгээ, хамгаалах нөхөн сэргээх арга зүй" сэдэвт сургалтад дүүргийн 43 хорооны халамжийн нийгмийн ажилтнуудыг	04.31-12.09	100%

					хамруулж ажиллалаа. Мөн хороодын нийгмийн ажилтнуудын дунд сар бүр Мэдээллийн цаг хөтөлбөрийг хэрэгжүүлж тогтмол арга зүйн дэмжлэг үзүүлэн, мэдээ мэдээллээр ханган ажиллаж байна.		
7.	Арга хэмжээ 3.2. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил, хамгааллын чиглэлээр ажиллаж буй албан хаагчдын ур чадварыг нэмэгдүүлэх, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах	Хамрагдах албан хаагч, давхардсан тоо	500	800	Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яам, ЗГХАгентлаг Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газар болон төрийн бус байгууллагуудтай хамтарсан 6 удаагийн чадавхжуулах сургалт, арга зүй өгөх нэгдсэн арга хэмжээнд 43 хорооны нийгмийн ажилтан, хамтарсан багийн 84 гишүүн, хэлтсийн 10 албан хаагч хамрагдсан. Нийт 5 удаагийн кейс хэлэлцүүлэгт давхартсан тоогоор 215 хорооны нийгмийн ажилтан, албан хаагч, "Нийгмийн хамгааллын алхмууд, кейс менежментийн арга зүй", "Хүүхэд хамгааллын шуурхай тусламж, үйлчилгээ, хамгаалах нөхөн сэргээх арга зүй" сэдэвт сургалтад "Хүүхэд хамгаалагч" төслийн 30 албан хаагчийг хамрууллаа. Мөн "Галт шувуу" төрийн бус байгууллагатай хамтран "Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал" сэдвээр 270 дугаар цэцэрлэгийн 35 багш, ажилчдын дунд сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулаад байна. Нийт сургалт, арга хэмжээнд 331 албан хаагчийг хамруулж, чадавхжуулаа. "Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын ажилтны өдөр"-ийг тохиолдуулан "Асуудал, шийдэл - 2024" арга хэмжээг дүүргийн салбар дундын нийгмийн ажилтан, гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил, хамгааллын чиглэлээр ажиллаж буй албан хаагчдын дунд хүүхэд	02.31-12.09	100%

					хамгааллын салбарын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааг дэмжих зорилготой "Эрдэм шинжилгээ, онол, практикийн бага хурал"-ыг зохион байгуулж, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харъяа байгууллагуудын 60 албан хаагчийн илтгэлийг хүлээн авч, шилдэг 5 илтгэлийг шалгаруулж ажиллалаа.		
Зорилт 4. "Төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, санал хүргүүлэх, гэрээ дүгнэх, тайлагнах" зорилтыг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт							
8.	Арга хэмжээ 4.1. Гэр бүл, хүүхэд, залуучуудыг хөгжүүлэх, тэдний эрхийг хамгаалах талаар төрийн бус байгууллагуудын санаачилгыг дэмжиж, хамтран ажиллах	Төрийн бус байгууллагын тоо	4	2	Нийт 3 удаагийн кейс хэлэлцүүлэгт 129 хорооны нийгмийн ажилтан, албан хаагч, "Нийгмийн хамгааллын алхмууд, кейс менежментийн арга зүй", "Хүүхэд хамгааллын шуурхай тусламж, үйлчилгээ, хамгаалах нөхөн сэргээх арга зүй" сэдэвт сургалтад "Хүүхэд хамгаалагч" төслийн 30 албан хаагчийг хамруулаа. Мөн "Галт шувуу", "Хүүхэд, гэр бүлийн тэгш хөгжил" төрийн бус байгууллагатай хамтран "Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал" сэдвээр 270 дугаар цэцэрлэгийн 35 багш, ажилчдын дунд сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулаад байна. Нийт сургалт, арга хэмжээнд 331 албан хаагчийг хамруулж, чадавхжуулаа.	01.01-12.09	100%
Зорилт 5. "Байгууллага, нэгжийн үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг үзүүлж, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх" зорилтыг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт							
9.	Арга хэмжээ 5.1. Дээд газраас ирүүлсэн тогтоол, шийдвэрийн биелэлтийг тооцож, хэрэгжилтийг хангах, хяналт шинжилгээ	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100%	50%	Дээд газраас ирүүлсэн тогтоол, шийдвэрийн биелэлтийг тооцож, хэрэгжилтийг ханган, хяналт шинжилгээ үнэлгээ хийлгэж, биелэлтийг хугацаанд нь хүргүүлэн ажиллаж байна.	03.01-12.09	100%

	үнэлгээ хийлгэж, биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх						
10.	Арга хэмжээ 5.2. Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан, биелэлтийг хагас, бүтэн жилээр гаргаж, тооцох	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100%	50%	Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж 2024 оны хагас жилийн гүйцэтгэлийн тайланг хүргүүлсэн.	01.31-12.09	100%
11.	Арга хэмжээ 5.3. Ирсэн бичгийн хэрэгжилтийг хангах, явуулсан бичгийг бүртгэх, баримт бичгийн эргэлтийн мэдээг сар тутамд гаргаж танилцуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100%	50%	2024 оны хагас жилийн байдлаар байдлаар 147 албан бичиг ирснийг шийдвэрлэсэн. Явсан 38 бичиг байна.	01.31-12.09	100%
12.	Арга хэмжээ 5.4. Албан хэрэг хөтлөлтийн систем /Edoc.ub.gov.mn/-д албан бичгийн шийдвэрлэлт, зөрчлийн байдалд хяналт тавьж ажиллах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100%	50%	2024 оны хагас жилийн байдлаар албан хэрэг хөтлөлтийн системд зөрчилгүй байна.	01.31-12.09	100%
13.	Арга хэмжээ 5.5. Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд хандан гаргасан өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэлтийн байдал, үр дүнд хяналт тавих	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100%	50%	2024 оны хагас жилийн байдлаар холбогдох хууль тогтоомжийн дагуу хүүхэд үрчлэх 146, асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоох 110, хүүхэд асруулах 9, асрамжийн газраас буцаан авах 21 буюу нийт 286 иргэний хүсэлтийг шийдвэрлэсэн байна.	01.31-12.09	100%

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. IELTS, TOEFL-д бэлдэх сургалтад хамрагдана.	Урт хугацааны сургалтад хамрагдсан байх	50%	100%	"The English Academy Of Mongolia" англи хэлний сургалтын төвийн суурьтай анхан шатнаас IELTS, TOEFL-д бэлдэх сургалтад хамрагдаж байна.	01.31-6.01	80%
2.	Арга хэмжээ 2. Нийслэл, дүүргээс зохион байгуулж буй төрийн албан хаагчдыг чадваржуулж, мэргэшүүлэх сургалтад тухай бүрд хамрагдах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100%	50%	Нийслэл, дүүргээс зохион байгуулж буй төрийн албан хаагчдыг чадваржуулж, мэргэшүүлэх сургалтад тухай бүрд хамрагдаж ажилласан.	01.31-6.01	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Нийгмийн хөгжлийн хэлтсийн Гэр бүл хүүхэд, залуучууд төрийн бус байгууллага хариуцсан мэргэжилтэн
(Албан тушаал)

Г.АНХЖАРГАЛ / ..... /
(Нэр, гарын үсэг)

2024.12.16
(Огноо)

56

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
8 дугаар хавсралт

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД, ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ГАНЦОЛМОНГИЙН АНХЖАРГАЛЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС
(ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛТАН)

Байгууллагын нэр: Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар

Нэгжийн нэр: Нийгмийн хөгжлийн хэлтэс

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
"Хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийг бууруулах талаар холбогдох шийдвэрүүдийг гарган, хүчирхийлэлд өртөгчдийг хамгаалах байртай болж, гэр бүлийн гишүүдийн хариуцлагыг нэмэгдүүлэн, үлгэр жишээ гэр бүлийг дэмжин, сурталчлах, хүүхдийн эрхийг дээдэлж, залуучуудыг хөгжих, суралцах, хөдөлмөрлөх орчин нөхцөлөөр хангана."					
Зорилт 1. "Төрөөс хүүхэд, залуучуудын талаар баримталж буй хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, хянах, тайлагнах" зорилтыг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
1.	Арга хэмжээ 1.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, тэдний эцэг эх, асран хамгаалагчдын нийгмийн оролцоог нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах	60	10	70	
2.	Арга хэмжээ 1.2. Залуу гэр бүлүүдэд зориулсан сургалт, нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулж хэвшүүлэх	60	10	70	
Зорилт 1.2. "Гэр бүлийн хөгжлийг дэмжих, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажлын хэрэгжилтийг хангуулах, судлах, хяналт тавих, тайлагнах" зорилтыг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
3.	Арга хэмжээ 2.1. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүдийг	42	10	52	

	хамгаалах байрны үйл ажиллагаанд арга зүйн дэмжлэг үзүүлэх, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг шуурхай хүргэх				
4.	Арга хэмжээ 2.2. Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдийг илрүүлэх, хүүхэд үрчлэлт болон асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоолгосон хүүхдүүдийн нөхцөл байдалд эргэн хяналт тавьж ажиллах	60	10	70	
5.	Арга хэмжээ 2.3. Байгууллагын дэргэдэх эцэг, эхийн зөвлөлийг арга зүйгээр хангаж, хүүхэд хүмүүжлийн эерэг аргыг түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах.	60	10	70	
6.	Арга хэмжээ 2.4. "Хүүхэд харах" үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд хяналт тавих, дэмжлэг үзүүлэх, зөвшөөрөл олгох, чадавхжуулах ажлыг зохион байгуулах.	42	10	52	
Зорилт 3. "Гэр бүл хүүхэд залуучуудын байгууллага болон хороодын нийгмийн ажилтнуудыг мэргэшил, арга зүйгээр хангах үйл ажиллагааны хэрэгжилтийг хангуулах, хянах, дүгнэх, тайлагнах" зорилтыг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
7.	Арга хэмжээ 3.1. Хороодын нийгмийн ажилтнуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах, тайлан мэдээг хянах, дүгнэх ажлыг зохион байгуулах	60	10	70	
8.	Арга хэмжээ 3.2. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил, хамгааллын чиглэлээр ажиллаж буй албан хаагчдын ур чадварыг нэмэгдүүлэх, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах	60	10	70	
Зорилт 4. "Төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, санал хүргүүлэх, гэрээ дүгнэх, тайлагнах" зорилтыг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					

9.	Арга хэмжээ 4.1. Гэр бүл, хүүхэд, залуучуудыг хөгжүүлэх, тэдний эрхийг хамгаалах талаар төрийн бус байгууллагуудын санаачилгыг дэмжиж, хамтран ажиллах	60	10	70	
Зорилт 5. "Байгууллага, нэгжийн үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг үзүүлж, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх" зорилтыг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
10.	Арга хэмжээ 5.1. Дээд газраас ирүүлсэн тогтоол, шийдвэрийн биелэлтийг тооцож, хэрэгжилтийг хангах, хяналт шинжилгээ үнэлгээ хийлгэж, биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх	60	10	70	
11.	Арга хэмжээ 5.2. Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан, биелэлтийг хагас, бүтэн жилээр гаргаж, тооцох	60	10	70	
12.	Арга хэмжээ 5.3. Ирсэн бичгийн хэрэгжилтийг хангах, явуулсан бичгийг бүртгэх, баримт бичгийн эргэлтийн мэдээг сар тутамд гаргаж танилцуулах	60	10	70	
13.	Арга хэмжээ 5.4. Албан хэрэг хөтлөлтийн систем /Edoc.ub.gov.mn/-д албан бичгийн шийдвэрлэлт, зөрчлийн байдалд хяналт тавьж ажиллах	60	10	70	
14.	Арга хэмжээ 5.5. Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд хандан гаргасан өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэлтийн байдал, үр дүнд хяналт тавих	60	10	70	
Дундаж оноо:				67.2	

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо

	1	2	3	4
1.	Арга хэмжээ 1. IELTS, TOEFL-д бэлдэх сургалтад хамрагдана.	80%	12	
2.	Арга хэмжээ 2. Нийслэл, дүүргээс зохион байгуулж буй төрийн албан хаагчдыг чадваржуулж, мэргэшүүлэх сургалтад тухай бүрд хамрагдах	100%	15	
Дундаж оноо			13.5	

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	5	
2.	Дүн шинжилгээ хийх	5	
3.	Асуудал шийдвэрлэх	5	
4.	Хариуцлагатай байдал	5	
5.	Ажлын цаг ашиглалт	5	
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
6.	Мэргэжлийн ур чадвар 1.		
Дундаж оноо		5	

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (0-8 оноо)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	6.4
2.	Багаар ажиллах	6.2
3.	Харилцаа	6.8
Дундаж оноо		6.4

5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)*	67.2
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	13.5
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Нэгжийн даргын үнэлгээ)*	5
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)*	6.4
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)*	*(..... оноо)*
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)*) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		92.1

Үнэлгээ өгсөн: ***Нэгжийн дарга***

НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ /.....Ц......./ (Т.БАЯРМАА)
(албан тушаал) *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

.....
(огноо)

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн: ***Төрийн жинхэнэ албан хаагч:***

НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД,
ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН
(албан тушаал) /.....Г......./ (Г.АНХЖАРГАЛ)
(гарын үсэг) *(албан хаагчийн нэр)*
2024.12.06
(огноо)

Үнэлгээг хянасан:

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА
(албан тушаал) /.....Туул.....Ц/ (С.ТУУЛМАА)
(гарын үсэг) *(албан хаагчийн нэр)*

2024.12.16.
(огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

ЗАХИРГААНЫ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
(албан тушаал) /.....Ц/ (Ц.САРАНЦЭЦЭГ)
(гарын үсэг) *(албан хаагчийн нэр)*

2024.12.16.
(огноо)

Үнэлгээг батлагаажуулсан: ***Төсвийн шууд захирагч***

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА
(албан тушаал) .....Д..... (Д.ТӨМӨРБААТАР)
(гарын үсэг) *(албан хаагчийн нэр)*

2024.12.18
.....
(огноо)

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН И.ОЮУНСУВДЫН
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН БОЛОВСРОЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ИЖИЙДААГИЙН ОЮУНСУВДЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2024 оны ....дугаар сарын ....ны өдөр Улаанбаатар хот

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин /биелэлт/		
	1	2	3	4	5	6	7
НЭГ. "АЛСЫН ХАРАА-2050" МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД:							
Зорилт 1. Монгол хэл, бичгээ үндэсний үнэт зүйлийн бүрдэл болгон иргэн бүр чанартай эзэмшиж, хэрэглэж хэвшинэ.							
1	Арга хэмжээ 1.1 Төрийн байгууллагын албан хаагч, ажилтнуудад "Монгол бичиг"-ийн анхан шатны мэдлэг олгох сургалтуудыг үе шаттай зохион байгуулах	Зохион байгуулсан сургалт, тоо	0	5	Төрийн байгууллагын албан хаагч, ажилтнуудад "Монгол бичиг"-ийн анхан шатны мэдлэг олгох сургалтыг төрийн 16 байгууллагад үе шаттайгаар зохион байгууллаа.	01.02-12.30	100
		Хамруулсан албан хаагч, тоо	0	100	"Монгол бичиг"-ийн анхан шатны мэдлэг олгох сургалтад төрийн байгууллагын 639 албан хаагч хамрагдсан.		
ХОЁР. НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХАМААРАЛТАЙ ЗААЛТУУДЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД:							
1	Арга хэмжээ 1.1.1. Индексийн урамшуулалд шалгарсан ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн туршлагыг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах.	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	1	2	2024 оны тэргүүний сургууль, цэцэрлэг шалгаруулах гүйцэтгэлийн үнэлгээний шалгалт ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад хийгдэж, гүйцэтгэлийн үнэлгээнд 1-4 дүгээр түвшинд үнэлэгдсэн 7 сургууль, 18 цэцэрлэг туршлагаа	01.02-12.30	100

					түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг зохион байгуулж, 79 сургалтад 5954 багш хамрагдсан.		
ГУРАВ. ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХҮРЭЭНД:							
Зорилт 3.1. Хүн бүр чанартай боловсролыг тэгш хүртээмжтэй, эзэмших нөхцөлийг бүрдүүлэх, насан турш сурч боловсрох боломжийг дэмжинэ.							
1	Арга хэмжээ 3.1.1 "Боловсрол" төслийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах	Хөтөлбөрийн хэрэгжилт, хувь	90	100	"Боловсрол" төслийн 2024 төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Цэцэрлэгийн багш нарт хүүхэд бүрийг хөгжүүлэх сургалтын арга зүй, хэрэглэгдэхүүний шинэ санаа, шинэлэг бүтээлийг түгээн дэлгэрүүлэх, туршлага солилцох "Бүтээлч багш-2024" үйл ажиллагаанд 77 багшийн бүтээл, соёлын дурсгалыг хадгалж хамгаалах, ардын ёс заншил, соёлын биет бус өв тээгчдийг нээн илрүүлэх, ардын бий биелгээг хөгжүүлэх, уламжлуулах, зааж сургах, өвлүүлэн түгээн дэлгэрүүлэх "Зөв Сонгинохайрхан-Бий биелгээ-2024" арга хэмжээнд 67 цэцэрлэгийн 440 гаруй багш ажилтан, 900 гаруй хүүхэд тус тус хамрагдлаа. Боловсролын байгууллагын багшийн хөгжил ур чадварыг ахиулах, нийгмийн баталгааг хангах, сургалтын арга зүй, орчин, боловсролын үйлчилгээний чанарыг сайжруулах "Шинэ үеийн багш-2024" зөвлөгөөнийг зохион байгуулж, 2280 багш, ажилтан, албан хаагчид хамрагдсан. Төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын 30 сургуулийн багш нарын дунд "Ур чадварын уралдааныг 16 судлагдахуун тус бүрээр зохион байгуулж, 287 багш хамрагдсанаас 1-р байр эзэлсэн 17 багш нийслэлийн ур чадварын уралдаанд оролцохоор болсон. Элсэлтийн ерөнхий	01.02-12.30	100

					шалгалтад 10 судлагдахуунаар давхардсан тоогоор нийт 6809 суралцагч элсэлтийн ерөнхий шалгалт өгч 13 суралцагч математик, физик, англи хэлний хичээлээр 800 оноо авч, элсэлтийн ерөнхий шалгалтын дүүргийн дундаж оноо 483,8 буюу аөмнөх оныхоос 3,45 оноогоор ахисан үзүүлэлттэй байна. Сурагчдын англи хэлний мэдлэгийг сайжруулах, олон улсын тэтгэлэгт хөтөлбөрт хамруулах зорилгоор "IELTS-600" төслийн хүрээнд "Инглиш академи оф монголиа" сургалтын төвийн сургалтад 25 сурагч суралцснаас 16 сурагч IELTS-ийн сургалтаа төгсч, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдахаар хүсэлтүүдээ өгч 2 суралцагч БНСУ-ын 50%-ийн тэтгэлэгт хамрагдаад байна. "Чадварлаг багш, шавь-2024" бага хурлыг зохион байгуулж, 35 сургуулийн 1200 багш, 115 цэцэрлэгийн 1800 багш хамрагдлаа.		
2	Арга хэмжээ 3.1.2 Төгсөх ангийн сурагчдын дунд "BOOM" төслийг хэрэгжүүлэх	Төслийн хэрэгжилт, хувь	100	100	Төгсөх ангийн сурагчдын дунд "BOOM" төслийг хэрэгжүүлэх ажлын удирдамж, төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.. 24 сургууль элсэлтийн ерөнхий шалгалтын хичээлүүдээр нэрэмжит шалгалт зохион байгуулсан. "Boom-2024" цахим хуудас болон сургуулийн удирдлагуудаар дамжуулан элсэлтийн ерөнхий шалгалттай холбоотой мэдээ мэдээллийг цаг тухай бүрд хүргэж ажиллаж байна. Элсэлтийн ерөнхий шалгалтад 10 судлагдахуунаар давхардсан тоогоор нийт 6809 суралцагч элсэлтийн ерөнхий шалгалт өгч 13 суралцагч математик, физик, англи хэлний хичээлээр 800 оноо авч, элсэлтийн ерөнхий шалгалтын дүүргийн дундаж оноо 483,8 буюу аөмнөх оныхоос 3,45 оноогоор ахисан үзүүлэлттэй байна.	01.02-12.30	100

		Хамрагдах хүүхэд, тоо	2220	2484	"BOOM" төслийн хүрээнд 2023-2024 оны хичээлийн жилийн 12 дугаар ангийн 87 бүлгийн 2484 суралцагчдын элсэлтийн ерөнхий шалгалт өгөхөөр бүртгүүлж, дүүргийн хэмжээнд 12 дугаар ангийн суралцагчдаа дэмжин ажиллаж байна. Элсэлтийн ерөнхий шалгалтын 10 судлагдахууны хичээл заадаг болон шалгалтад бэлтгэж буй 957 багш шалгалтад бэлтгэх давтлагыг хуваарийн дагуу зохион байгуулж, элсэлтийн ерөнхий шалгалтын ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна. ЭЕШ-д 13 суралцагч 800 оноо авсан.		
3	Арга хэмжээ 3.1.3 Суралцагчдын гадаад хэлний мэдлэгийг нэмэгдүүлэх, багш нарын ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор суралцагчдын дунд "IELTS-600" төслийг хэрэгжүүлэх	Төслийн хэрэгжилт, хувь	100	100	Сурагчдын англи хэлний мэдлэгийг сайжруулах, олон улсын тэтгэлэгт хөтөлбөрт хамруулах зорилгоор "IELTS-600" төслийн хүрээнд "Инглиш академи оф монголиа" сургалтын төвийн сургалтад 25 сурагч суралцснаас 16 сурагч IELTS-ийн сургалтаа төгсч, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдахаар хүсэлтүүдээ өгч 2 суралцагч БНСУ-ын 50%-ийн тэтгэлэгт хамрагдаад байна.	01.02-12.30	100
		Хамрагдах хүүхэд, тоо	21	25	"IELTS-600" төслийн хүрээнд "Инглиш академи оф монголиа" сургалтын төвийн сургалтад 25 сурагч суралцснаас 16 сурагч IELTS-ийн сургалтаа төгссөн.	01.02-12.30	100
4	Арга хэмжээ 3.1.4 Цэцэрлэгийн багш нарын мэдлэг, ур чадвар, гүйцэтгэлийн үнэлгээг сайжруулах	Хамрагдах багш, тоо	4974	5103	Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнг сайжруулах зорилгоор удирдах ажилтны удирдан зохион байгуулах, манлайлах, хувь хүний хөгжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, туршлага хуримтлуулах, чадваржуулах 2 өдрийн сургалт зохион байгуулж, төрийн өмчийн сургуулийн өмнөх боловсролын 67 байгууллагын эрхлэгч, арга зүйч 150 багш хамрагдсан. Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээнд сургуулийн өмнөх боловсролын 67 байгууллага хамрагдсан.	01.02-12.30	100

					Гүйцэтгэлийн үнэлгээнд 1-4 дүгээр түвшинд үнэлэгдсэн 18 цэцэрлэг туршлагаа түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг зохион байгуулж, 61 сургалтад давхардсан тоогоор 5103 багш хамрагдсан. Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээнд 67 сургуулийн өмнөх боловсролын байгууллага хамрагдснаас 17 байгууллага, 332 багш 377,0 сая төгрөгийн урамшуулал авсан. Нийслэлийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагууддын бүлгийн багш нарын ур чадварын уралдаанд 101 дүгээр цэцэрлэгийн бүлгийн багш Ч.Энхцэцэг гутгаар байранд орсон.		
5	Арга хэмжээ 3.1.5 Олон улсын хөтөлбөртэй сургалтын хөтөлбөрийг өргөжүүлэх, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	90	100	151 дүгээр сургууль кембрижийн үнэлгээний олон улсын боловсролын хөтөлбөрөөр 6-р ангийн 3 бүлгийн 110 сурагчдад англи хэлний гүнзгийрүүлсэн хэлбэрээр туршилтын сургалт мөн математик, физик, хими, биологи, мэдээллийн технологийн багш нар хичээлээ монгол-англи хэлээр хослуулан заах туршилт судалгаат хичээлүүд орж байна. Гадаад хэлний лингафоны 2 танхим, 35 компьютер, ухаалаг самбар бүхий мэдээллийн технологийн кабинет, химийн лаборатори бүхий кабинет, хөгжлийн төв тохижуулж ашиглалтад орсон. Монгол-Оросын хамтарсан 162 сургуулийн 1-2 дугаар ангийн 277 суралцаг чдийн үдийн хоолны зардал, гэрээгээр ажиллаж буй 10 багш, 151 дүгээр сургуулийн 1 багшийн амьдрах орон сууцны түрээс, ашиглалтын зардал, кембрижийн хөтөлбөрийн жилийн хураамжийг /3380 евро буюу 12,556,700 төгрөг/ шийдвэрсэн.	01.02-12.30	100
6	Арга хэмжээ 3.1.6 Сургуулийн цайны газрын гал тогооны тоног төхөөрөмжийг	Хамрагдах	15	12	Ерөнхий боловсролын 65, 67, 124, 105, 107, Ирээдүй, Өнөр сургуулийн цайны газарт 391,2 сая төгрөгийн их засварын ажил хийгдэж, 14	01.02-12.30	70

	стандартын шаардлагад нийцсэн тоног төхөөрөмжтэй болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулах	сургууль, тоо			сургуульд /12, 67, 74, 104, 121, 124, 129, 152, 153, 154, 162, 168, Өнөр, Хөгжил/ хүүхдийн хоолны ширээ 69, сандал 285, цэвэр усны баллон 75, цэвэр усны шугамын холболт 23, шарах шүүгээ 2, хөргөгч 3, хөлдөөгч 6, гурил зуурагч 3, махны машин 3, аяга таваг ариутгагч 3, ногоо арилгагч 2, ногоо хэрчигч 1, дээжийн хөргөгч 2, бэлтгэлийн ширээ 10, хоол халуун байлгагч 4, аяга таваг угаагч автомат машин 1 гэх 17 төрлийн тоног төхөөрөмж, тавилгыг нийлүүлж, сургуулийн цайны газрын гал тогооны тоног төхөөрөмж, тавилгыг шинэчилсэн.		
7	Арга хэмжээ 3.1.7 Сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний стандартад хяналт тавих, хоол үйлдвэрлэл үйлчилгээний туршлагыг түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах	Зохион байгуулах ажил, тоо	2	2	Хүүхдийн шим тэжээлийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн ашиглан хоолны шинэлэг жор, технологи боловсруулан нэр төрлийг нэмэгдүүлэх, шим тэжээлийн дутлыг бууруулах, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний ажилтан, тогооч нарын мэдлэг мэдээлэл, ур чадварыг сайжруулах туршлага солилцох сургалт, ур чадварын уралдааныг зохион байгуулж, сургуулийн өмнөх боловсролын төрийн өмчийн 67, төрийн бус өмчийн 49 цэцэрлэгүүдийн нийт 116 тогооч хамрагдсан. Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн хоол шим тэжээлийг сайжруулах, болзошгүй эрсдэлээс сэргийлэх зорилгоор Шинжлэх ухаан технологийн их сургуультай хамтран зохион байгуулсан “Хүүхдийн хоол шим тэжээлийн байдлыг сайжруулах” сургалтад 28 сургуулийн тогооч хамрагдсан.“Монголын ресторан зоогийн газрын холбоо” ТББ-тай хамтран “Олон улсын хоолны жор, технологи” сургалтад 26 сургууль, 63 цэцэрлэгийн нийт 89 тогооч хамрагдсан.Хүүхдийн кальци, Д амин дэмийн дутагдлыг нөхөх, ясны сийрэгжилтээс	01.02-12.30	100

					урьдчилан сэргийлэх, дархлааг сайжруулж, өсөлт хөгжлийг дэмжих зорилгоор агаарын бохирдол ихтэй бүсэд байрших ерөнхий боловсролын 143, 151 дүгээр сургуулиудад "Сүү" зорилтот төслийг хэрэгжүүлэн 1-9 дүгээр ангийн 2167 суралцагчийн 7 хоногийн 1 өдрийн сүүний зардлыг /67,285,350 төгрөг/ шийдвэрлэсэн. "Шим тэжээлийн боловсрол олгох" нөлөөллийн аяны хүрээнд 54470 суралцагчдад "Хүнсний бүтээглэхүүний шим тэжээл болон хүнсний бүлэг, зөв зохистой болон тэнцвэртэй хооллолт"-ын талаар мэдээлэл өгч, хүнсний бүтээгдэхүүний хаяг шошго, зөв хадгалалтын талаар зөвлөмж мэдээлэл өгсөн.		
8	Арга хэмжээ 3.1.9 Суралцагчдад ээлтэй, эрүүл, аюулгүй орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор "Сурагч тээвэр" үйлчилгээ үзүүлж буй сургуулийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт хувь	90	100	2023-2024 оны хичээлийн жилд "Хүүхдийн сургуулийн автобус" төслийн хүрээнд 14 сургууль хүүхдийн автобусаар батлагдсан маршрутын дагуу 267,600 хүүхдэд үйлчилгээ үзүүлж байна. 152 дугаар сургуульд нэмэлтээр 1 хүүхдийн автобусыг чиглэл батлуулан явуулаад байна. Жолооч, хүүхэд зохицуулагчийн цалин, шатахууны зардалд 87,4 сая төгрөг шийдвэрлэсэн.2024-2025 оны хичээлийн жилд "16 хүүхдийн автобусыг Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1110 дугаар захирамжийн дагуу "Зорчигч тээврийн 1, 3, 5 дугаар бааз" ОНӨААТҮГ-уудад хүлээлгэн өгч Нийслэлийн Нийтийн Тээврийн газрын батлагдсан маршрутын дагуу 16 сургуульд сургуулийн автобус үйлчилгээ үзүүлж байна.	01.02-12.30	100
9	Арга хэмжээ 3.1.10 Сургуулийн сэтгэл зүйчдийн туршлага солилцох арга хэмжээг зохион байгуулах	Сургууль, тоо	27	28	Ерөнхий боловсролын сургуулийн орчинд хүүхдийн эрүүл аюулгүй орчинд амьдарч, сурч боловсрох, хамгаалагдах эрх зөрчигдөж хүүхэд хамгаалал, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, үе тэнгийн дээрэлхэлт ихсэж байгаатай	01.02-12.30	100

					холбогдуулан сэтгэл зүйчдийг, чадавхжуулах мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор 28 сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэлзүйч 75 хүн, хүүхдэд сэтгэлзүйн зөвлөгөө өгөх ур чадварыг сайжруулах чадавхжуулах сургалтад хамруулсан.		
10	Арга хэмжээ 3.1.11 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан сургах нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ зохион байгуулах	Зохион байгуулах сургалт, тоо	0	1	Цэцэрлэгт 145 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, ерөнхий боловсролын сургуульд 364 сурагч хамрагдаж, 243 сурагч ганаарчилсан хөтөлбөрөөр хичээллэж байна Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан сургах 6 сургалтад 150 багш, 37 эцэг эх, "Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөнд суралцахуйн түгээмэл загварын зарчмыг тусгах нь" онол, арга зүйн сургалтыг 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулж, төрийн болон төрийн бус өмчийн цэцэрлэгийн 144 багш, сургуулийн 56 багш нийт 200 багш хамрагдан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн танин мэдэхүйн хөгжлийн үнэлгээнд хамруулах өдөрлөгийг бүсчлэн 2024 оны 5 дугаар сарын 13-14-ны өдрүүдэд зохион байгуулсан. Ерөнхий боловсролын 6 сургуулийн "Дэмжлэгийн баг"-т ирсэн гомдлыг тухай бүрд нь шийдвэрлэн ажилласан.	01.02-12.30	100
11	Арга хэмжээ 3.1.12 Тусгай хэрэгцээт хүүхдийн цэцэрлэгийн барилгыг ажлыг дуусган, ашиглалтад оруулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах	Цэцэрлэгийн барилгын ажлын явц, хувь	40	100	28 дугаар хороонд баригдаж буй тусгай хэрэгцээт хүүхдийн 341 дүгээр цэцэрлэгийн барилгын ажил 100%-ийн гүйцэтгэлтэй, Улсын комисс ажилласан.	01.02-12.30	100
Зорилт 3. 2. Хүүхэд бүрийг үр дүнтэй сургах, хөгжүүлэх, үндэсний өв уламжлал, хэл, ёс заншилаа дээдэлсэн, эх оронч зөв үзэл хандлагатай соёлтой иргэн төлөвшүүлэх							
12	Арга хэмжээ 3.2.1 Ерөнхий боловсролын сургууль болон сургуулийн өмнөх	Зохион байгуулах арга	2	2	Соёлын дурсгалыг хадгалж хамгаалах, ардын ёс заншил, соёлын биет бус өв тээгчдийг нээн илрүүлэх, ардын бий биелгээг хөгжүүлэх,	01.02-12.30	100

	боловсролын байгууллагуудын дунд соёлын биет бус өвийг уламжлуулах түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг зохион байгуулах	хэмжээ, тоо			уламжлуулах, зааж сургах, өвлүүлэн түгээн дэлгэрүүлэх "Зөв Сонгинохайрхан-Бий биелгээ-2024" арга хэмжээнд 67 цэцэрлэгийн 440 гаруй багш ажилтан, 900 гаруй хүүхэд тус тус хамрагдлаа.		
13	Арга хэмжээ 3.2.2 Сургууль дээрх болон хичээлээс гадуурх хүүхэд хөгжүүлэх дугуйлан, секцийн үйл ажиллагаанд хүүхдүүдийг хамруулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	50	50	Төрийн болон төрийн бус өмчийн нийт ерөнхий боловсролын 35 сургууль нийт 188 клуб, 715 секц, дугуйланд нийт 25227 сурагч хамрагдаж, 687 багш удирдан хичээллүүлсэн. Дугуйлан секцийг ангиллаар авч үзвэл: - Урлаг 151, Спортын 203, Техникийн 34, Математикийн 85, Илтгэх 34, Бусад 208	01.02-12.30	70
Зорилт 3.3. Насан туршийн боловсролыг бүх нийтийн боловсролоор соён гэгээрүүлэх гол хэрэглүүр, насанд хүрэгчдийн боловсролын үйлчилгээ хэлбэрээр хөгжүүлж, амьдрах аргад тасралтгүй суралцдаг, ур чадвартай иргэн төлөвшүүлэх							
14	Арга хэмжээ .3.1 Сургууль завсардалтыг бууруулах ажлыг боловсрол нөхөн олгох сургалтаар зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	0	50	Сургууль завсардалтыг бууруулах ажлын хүрээнд Боловсрол нөхөн олгох сургалтад 185 суралцагч 2 ээлжинд 4 байршилд 8 бүлгээр суралцаж байгаагаас 35 нь бага боловсрол, 60 нь суурь, 63 нь бүрэн дунд боловсрол нөхөн олгох сургалтад, 27 иргэнд бичиг үсийн анхан шатны боловсрол тус тус хамрагдан суралцаж байна.	01.02-12.30	100
15	Арга хэмжээ 3.3.2 Иргэдийн хэрэгцээнд тулгуурлан боловсролын ерөнхий түвшин дээшлүүлэх үндсэн 6 чиглэл /Амьдрах ухаан, Ёс суртахуун төлөвшил, Гоо зүй, Гэр бүл, Шинжлэх ухаан, Иргэний боловсрол/-ийн сургалтыг зохион байгуулах	Хамрагдах хүн, тоо	200	125	Иргэдийн боловсролын түвшинг дээшлүүлэхээр 9 төрлийн 141 удаагийн сургалтыг 11519 иргэнд, 98 нөлөөллийн ажлыг 10259 иргэнд тус тус зохион байгуулсан /Амьдрах ухаан, Ёс суртахуун төлөвшил, Гоо зүй, Гэр бүл , Шинжлэх ухаан, Иргэний боловсрол, Гадаад хэл, Үндэсний бичиг, Мэргэжлийн сургалт, Мэдээлэл харилцааны технологи/	01.02-12.30	100
ДӨРӨВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1	Арга хэмжээ 4.1.1 Ерөнхий боловсролын сургуулийн 8 барилга /10, 20, 27, 28, 30, 31,	Ашиглалтад орох	0	2	Ерөнхий боловсролын сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 18-р хорооны 12, 40-р дүгээр хорооны 168, 10-р хорооны 169	01.02-12.30	70

	32, 40-р сургууль/, барилгын 1 /76-р сургууль/ өргөтгөл, шинээр барих /12-р сургууль/ ажлуудыг үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах	сургууль , тоо			дугаар сургууль ашиглалтад орсон, 5 сургуулийн барилгын ажлын (20, 27, 28, 30, 31, 32) гүйцэтгэл 20-90%-ийн гүйцэтгэлтэй, 1 сургуулийн барилгын ажил эхлээгүй. Мөн бага сургууль, цэцэрлэгийн 6 (7, 8, 21, 24, 33-р хороо) цогцолбор барилгын ажил 40-90%-тай, 1 сургуулийн (76) өргөтгөлийн барилгын ажил 90%-тай зогссон, 62-р сургуулийн өргөтгөлийн барилгын төсөв батлагдан тендер зарлагдсан.		
2	Арга хэмжээ 4.1.2 Цэцэрлэгийн 12 барилга /7, 22, 23, 25, 27, 28, 29, 34/2/, 40, 42, 43/ цэцэрлэгийн 2 /84, 176/-н өргөтгөл , дахин шинээр барих барилгын ажлуудыг үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах	Барилгын ажлын явц, хувь	0	3	Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хүртээмжийг нэмэгдүүлэхээр буулгаж шинээр барьсан 84-р цэцэрлэг, 7-р хорооны 340, 22-р хорооны 332, 25-р хорооны 333-р цэцэрлэгүүд ашиглалтад орж, /23, 27, 28, 29, 34/2/, 40, 42, 43/, хороонд 9 цэцэрлэгийн барилгын ажил явагдаж 1 барилга 15%, 8 барилга 60-100%-ийн гүйцэтгэлтэй, 107-р цэцэрлэгийн өргөтгөлийн барилга улсын комисс ажилласан, 176-р цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын ажил 100%-ийн гүйцэтгэлтэй байна.	01.02-12.30	70
3	Арга хэмжээ 4.1.3 Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш нарын дунд бүтээлч багш нарыг шалгаруулах, туршлагыг түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг зохион байгуулах	Зохион байгуулах ажил, тоо	1	1	Цэцэрлэгийн багш нарт хүүхэд бүрийг хөгжүүлэх сургалтын арга зүй, хэрэглэгдэхүүний шинэ санаа, шинэлэг бүтээлийг түгээн дэлгэрүүлэх, туршлага солилцох "Бүтээлч багш-2024" үйл ажиллагааг зохион байгуулж 77 багшийн бүтээл шалгарсан.	01.02-12.30	100
